БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: **ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Баталгаажуулсан: ***Төсвийн Шууд захирагч***

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ЦЭНГЭЛ

20.... оны .... сарын ....-ны өдөр

Хянасан: ***Нэгжийн дарга***

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Н.ГАНБОЛД

20.... оны .... сарын ....-ны өдөр

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

(Жилийн эцсийн тайлан, 2021.12.10-ны өдрийн байдлаар)

2021.12.10 Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (ТӨБЗГ)-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан журам, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, заавар, загварын дагуу боловсруулж, батлан хэрэгжилтийг ханган ажиллав. Төлөвлөгөөнд “Байгууллагын стратеги төлөвлөгөө”-тэй уялдуулсан 21 зорилт, 82 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Эдгээр зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд ТӨБЗГ-ын 2021 оны батлагдсан төсөв болох нийт 1,209.3 сая төгрөгийг зарцуулахаар тооцсон. Байгууллагын гүйцэтгэлийн тайланг дээр дурдсан холбогдох журам, аргачлал, зааврын дагуу нэгтгэн боловсруулав.

Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн тухайн жилийн зорилт, арга хэмжээ	**Төсөв**	**Шалгуур үзүүлэлт**	**Суурь түвшин**	**Зорилтот түвшин**	**Хугацаа (I-IV улирал),** **Хариу-цах нэгж**	**Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/,** **Гүйцэтгэлийн хувь**
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, эрх зүйн орчныг боловсронгуй болгон оновчтой бодлого, чиглэлийг хэрэгжүүлнэ.						
Зорилт 1. **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, тогтоол шийдвэрийн төсөл боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулна.**	**210.6 сая**	- **Холбогдох хуулийн төслийг боловсруул-сан эсэх;** - **УИХ-д өргөн мэдүүлсэн эсэх;** - **Дагалдах журам, дүрмийг боловсруул-сан байдал;** - **Олон нийтэд нээлттэй мэдээлж,**	**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалт өнөөгийн байдалд нийцэхгүй, өмчийн харилцааг бүрэн зохицуулах боломжгүй, бусад хууль болон зарим зүйл, хэсэг**	- **Хуулийн төслийг боловсруул-сан байна;** - **УИХ-д өргөн мэдүүлж, хэлэлцүүлэн батлуулсан байна;** - **Дагалдах 2-3 журам, дүрмийг боловсруул-сан байна;** - **Хууль тогтоомж,**	**I-IY улирал,** **ТӨУЗХ ТӨБАХ ТӨХШХ ЗУХ ХЭЗХ МТА**	**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг МУИС-ийн хуулийн багш нарын баг, хэлтсийн дарга нартай хамтран боловсруулж, холбогдох яам, газрын саналыг тусган ЗГХЭГ-т хүргүүлэв.** **ЗГХЭГ-ын даргын 2021 оны 29 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд уг ажлын хэсгийн хуралд ТӨБЗГ-аас холбогдох төлөөлөл 2 удаа оролцсон. Ажлын хэсгийн хуралд хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас танилцуулсан.** **(82.5 хувь)**

		санал, шүүмжлэлийг авах боломжийг бүрдүүлсэн байх.	**хоорондоо зөрчилтэй.**	**журам, дүрмийн төсөлд олон нийтийн саналыг тусгасан байна.**		
Арга хэмжээ 1.1. (1) Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах	56.0 сая	- Хуулийн төслийг боловсруулсан байх; - Олон нийтийн саналыг авч, тусгах арга хэмжээ авсан байх; - УИХ-д өргөн мэдүүлсэн байх.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн судалгааны ажил хийгдсэн. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгагдсан.	- Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, хэлэлцүүлсэн байна; - Олон нийтийн саналыг авч, тусгасан байна.	I-IY улирал, ХЭЗХ ТӨУЗХ ТӨБАХ ТӨХШХ ЗУХ МТА	Хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн А-1/362 тоот албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тухайн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд засвар оруулан найруулж ирүүлсэн бөгөөд Ажлын хэсгийн саналыг тусган 2021 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1/1951 тоот албан бичгээр хүргүүлэв. Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу дараах бүрдүүлбэрийг гүйцэтгэж, хуулийн төсөлд хавсаргав: – Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ; – Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо; – Хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаарх судалгаа; – Бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаарх судалгаа; – Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай мэдээллийг шинэчлэн гаргав. (100 хувь)
Арга хэмжээ 1.2. **(2)** Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төсөл боловсруулах	36.2 сая	- Хуулийн төсөлд тусгах саналыг хууль санаачлагчид хүргүүлсэн байх; - Олон нийтийн саналыг авч,	Компанийн тухай хуульд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн асуудлаар эрх зүйн	- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн асуудлаарх зохицуулалт, төрийн	I-II улирал, ХЭЗХ ТӨУЗХ ТӨБАХ ТӨХШХ ЗУХ	Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төсөлд санал боловсруулж, дараах байгууллагад тус тус хүргүүлэв: – Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг судлан үзээд, саналаа 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А-1/939 тоот албан бичгээр ЗГХЭГ-т;

		тусгах арга хэмжээ авсан байх.	зохицуулалт байхгүй.	эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхой тусгасан байна; - Хууль, эрх зүйд нийцсэн, үндэслэл бүхий саналыг хууль санаачлагчид хүргүүлсэн байна; - Олон нийт, оролцогч талын саналыг тусгасан байна.	МТА	– Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд санал авах тухай 2021 оны 1/4410 тоот албан бичгээр ирүүлсэн хуулийн төсөлд тусгуулахаар холбогдох санал боловсруулж, 2021 оны 11 дүгээр сарын 10-ний өдрийн 1/1833 тоот албан бичгээр. (100 хувь)
Арга хэмжээ 1.3. **(3)** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэлтэй холбоотой дагалдан гарах дүрэм, журам болон бодлого, чиглэлийг боловсруулах	23.4 сая	- Дагалдан гарах дүрэм, журмын төслийг боловсруулсан эсэх; - Олон нийт, хэрэглэгч, оролцогч талуудын саналыг авч, тусгах арга хэмжээ авсан байх.	- Шинэчлэн батлах шаардлагатай 6 журам байна; - Төрийн өмчийн талаарх бодлого тодорхой бус байна.	- Дагалдан гарах 2-3 журмын агуулгыг тодорхойлж, төслийг боловсруулсан байна; - Улсын хөгжлийн дунд хугацааны бодлого болох холбогдох “Хөгжлийн зорилтот хөтөлбөр”-т	II-IY улирал, ХЭЗХ ТӨУЗХ ТӨБАХ ТӨХШХ ЗУХ МТА	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хууль санаачлагчийн зүгээс УИХ-д өргөн бариагүй, хууль батлагдаагүй байгаа учир тухайн журмуудад өөрчлөлт оруулах боломжгүй байгаа болно. Уг асуудал нь ТӨБЗГ-аас хамаарахгүй байна. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн. УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд ТӨБЗГ-ын хариуцан хэрэгжүүлэх 2 зорилт, арга хэмжээ, Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний

				тодорхой бодлогын зорилтыг тодорхойлон тусгасан байна.		жагсаалтад 1 арга хэмжээ тус тус тусгагдсан байна. Монгол Улсын хөгжлийн дунд хугацааны буюу 10 жилийн “Хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийг Засгийн газраас боловсруулж байгаатай холбоотойгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрхэлсэн асуудлаар нөхцөл байдлын шинжилгээг хийж, 2021 оны А-1/1647 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. (100 хувь)
Арга хэмжээ 1.4. **(4)** Бусад хууль тогтоомжийн хүрээнд батлагдах дүрэм, журмын төслийг боловсруулах	10.5 сая	- Дүрэм, журмын төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэх; - Олон нийт, хэрэглэгч, оролцогч талуудын саналыг авч, тусгах арга хэмжээ авсан байх.	Зарим хууль тогтоомжийн хүрээнд судалгаа хийгдсэн.	- Дүрэм, журмын төслийг хуульд нийцүүлэн үндэслэл бүхий боловсруулсан байна; - Дүрэм, журмын төслийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна; - Олон нийт, хэрэглэгч, оролцогч талуудын саналыг авч, тусгасан байна.	II-IY улирал, ХЭЗХ ТӨУЗХ ТӨБАХ ТӨХШХ ЗУХ МТА	Хууль санаачлагч байгууллагаас санал авахаар тус байгууллагад хандан ирүүлсэн нийт 15 хуулийн төсөл, Засгийн газраас ирүүлсэн 3 тогтоол, 3 журмын төсөлд тус тус санал боловсруулан хүргүүлж, 1 хэрэг маргааны талаарх судалгаа хийсэн байна. Тайлант хугацаанд дараах нэр бүхий хуулийн төсөлд санал хүргүүлсэн байна: 1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай; 2. Шилэн дансны тухай; 3. Газрын ерөнхий хууль; 4. Кадастрын тухай; 5. Газрын төлбөрийн тухай; 6. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай; 7. Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай; 8. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үеийн эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх тухай; 9. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай; 10. Монгол Улсын Засгийн газрын тухай; 11. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай; 12. Зөвшөөрлийн тухай; 13. Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай; 14. Үндэсний баялагийн сангийн тухай;

						15. Хөгжлийн сангийн тухай. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой 105 хуулийн этгээдэд ТӨБЗГ-ын 2021 оны “Санал авах тухай” А-1/336 тоот албан бичиг хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн төсөлд тусгах саналыг боловсруулсан. Орон нутгийн өмчийн асуудал хариуцсан байгууллагад холбогдон үүссэн хэрэг, маргааны талаарх судалгаа хийх зорилгоор Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар болон 21 аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2021 оны “Судалгаа ирүүлэх тухай” А-1/239 тоот албан бичиг хүргүүлсэн. Уг судалгааны хүрээнд иргэний 12, захиргааны 14, эрүүгийн 5, нийт 31 хэргийн тухай мэдээлэл ирүүлснийг нэгтгэн дүгнэв. (100 хувь)
Арга хэмжээ 1.5. **(5)** Төрийн өмчийг 2021-2024 онд хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл, хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалтын төслийг боловсруулах	12.6 сая	- Холбогдох судалгаа, тооцоолол хийсэн байх; - Үндсэн чиглэлийн төслийг боловсруулсан байх; - Хууль тогтоомжийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу боловсруулсан байх.	- 2018 онд УИХ-ын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн; - Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан; - 2019 онд Засгийн газраас төслийг эгүүлэн татах	- Судалгааны хийсэн байна; - Холбогдох төрийн захиргааны төв байгууллагын бодлогод нийцүүлж, саналыг тусгасан байна; - Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл, жагсаалтын төслийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх	II-IV улирал, ТӨУЗХ	Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийг хувьчлах, өөрчлөн байгуулах, бүтцийн өөрчлөлт хийх, нэгтгэх чиглэлээр санал боловсруулсан боловч хуулийн шинэчлэл батлагдаагүй байгаатай холбоотойгоор хойшлогдсон. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-д “Төрийн банк” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн нийт хувьцааг арилжих заалт тусгагдсан тул “Төрийн банк” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх, нэмж хувьцаа гаргахтай холбоотой асуудлыг Үнэт цаасны тухай хууль болон тус хуульд заасан Санхүүгийн зохицуулах хорооны баталсан холбогдох журмууд, бусад хууль тогтоомж, бодлого, чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх тухай санал болон холбогдох тодруулгыг Сангийн сайдад хүргүүлсэн.

			шийдвэр гаргасан.	газарт хүргүүлсэн байна; - Холбогдох хуулийн дагуу Хөгжлийн зорилтот хөтөлбөрт тусгах асуудлыг шийдвэрлэсэн байна.		Төрийн банкийг хувьчлах тухай УИХ болон ЗГ-ын шийдвэрийн төсөлд саналаа хүргүүлсэн. (70 хувь)
Арга хэмжээ 1.6. **(6)** Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг шинэчлэн, боловсруулж, батлуулах	10.1 сая	- Холбогдох судалгаа, тооцоолол хийсэн байх; - Холбогдох яамдын саналыг тусгасан байх; - Холбогдох хууль тогтоомж, журамд нийцсэн шийдвэрийн төсөл боловсруулсан байх; - Жагсаалт, шийдвэрийн төслийг Засгийн газарт хүргүүлсэн эсэх.	- УИХ-ын 1999 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан жагсаалт хүчин төгөлдөр байгаа; - Цаг үеийн шаардлага, нөхцөл байдлын улмаас уг жагсаалтаас зарим эд хөрөнгийг хасуулах, нэмүүлэх тохиолдол гарч байсан; - Жагсаалтыг хууль, эрх зүйн шинэчлэлд нийцүүлэн шинэчлэх шаардлага-тай.	- Судалгаа хийсэн байна; - Холбогдох яамдаас санал авч нэгтгэсэн байна; - Жагсаалтыг батлах тухай УИХ-ын шийдвэрийн төсөл боловсруулсан байна; - Төслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (цаашид “ТӨБЗГ” гэх)-ын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газарт хүргүүлсэн байна; - Холбогдох хуулийн дагуу	I-IY улирал, ТӨУЗХ	Холбогдох яамдаас санал авч нэгтгэн Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг боловсруулан эрх бүхий байгууллагад хүргүүлсэн боловч хуулийн шинэчлэл болон үндсэн чиглэл батлагдаагүй байгаатай холбоотой хойшлогдсон. Уг жагсаалтыг эдгээр хууль тогтоомж батлагдахаар уялдуулан боловсруулах шаардлагатай гэж үзсэн. (70 хувь)

				Хөгжлийн зорилтот хөтөлбөрт тусгах асуудлыг шийдвэрлэсэн байна.		
Арга хэмжээ 1.7. **(7)** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах журам боловсруулах	20.1 сая	- Сонгон шалгаруулалт хийх журам боловсруулсан эсэх; - Журмын төсөлд сонирхогч, оролцогч бүлгийн саналыг авах арга хэмжээ авах; - Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх.	Төрийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагыг томилж, нэр дэвшүүлэх сонгон шалгаруулал-тын журам байхгүй.	- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэх журмын төсөл боловсруулсан байна; - Хууль тогтоомжид нийцсэн байна; - Төслийг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан байна.	II-IY улирал, ТӨУЗХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах асуудлыг тодорхой тусгаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. (70 хувь)
Арга хэмжээ 1.8. **(8)** Төрийн өмчит хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг нэгтгэн судалгаа шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх аргачлал	20.1 сая	- Аргачлалыг хууль, эрх зүйд нийцсэн, эдийн засаг, шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулсан байх; - Холбогдох мэргэжлийн байгууллага,	Аргачлал байхгүй.	- Аргачлалын төслийг үндэслэлтэй, оролцогч, хэрэглэгч талын саналыг тусган боловсруулсан байна; - Төслийг ТӨБЗГ-ын	III-IV улирал, ТӨУЗХ	Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 43 дугаар захирамжаар байгуулагдсан Төрийн өмчит хуулийн этгээд (Улсын төсөвт үйлдвэрийн газар, Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Төрийн өмчит компани, Төрийн өмчийн оролцоотой компани)-ийн эрх зүйн байдал, зааг ялгаа, чиг үүргийг судалж, тэдгээрийн үйл ажиллагаанд цогц байдлаар дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах ажлын хэсэгт газрын дарга болон холбогдох хэлтсийн дарга нар ажилласан.

боловсруулах		хэрэглэгч, оролцогч бүлгийн саналыг тусгасан байх.		хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан байна.		Захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны А/60-в, 2020 оны А/60-б дугаар тушаалаар дэд ажлын хэсгүүдийг ажиллуулан дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: – Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2019 оны жилийн эцсийн байдлаарх санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн судалгаа; – Төрийн өмчит үйлдвэрийн газруудын санхүү; эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн судалгаа; – Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын 2019 оны санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн судалгаа; – Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийт ажиллагсдын тоо, нийт цалингийн сан, ажилчдын дундаж цалингийн судалгаа. Улсын төсөвт хуулийн этгээдийн цалингийн судалгааг тус тус гаргаж, газрын удирдлагуудад танилцуулан Ажлын хэсэг болон Сангийн Яаманд хүргүүлсэн. Ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлтийг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. (50 хувь)
Арга хэмжээ 1.9. **(9)** “Төрийн өмчийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулах, батлуулах	21.6 сая	- Журмын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан байх; - Холбогдох мэргэжлийн байгууллага, хэрэглэгч, оролцогч бүлгийн саналыг	- ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг	- Тогтоол шийдвэр, журмын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, холбогдох хэлтэс, албаны санал авсан байна. - Журмын шинэчлэн	II-IV улирал, ТӨБАХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдаагүй байгаа бөгөөд шинэчлэн батлагдсан нөхцөлд журамд өөрчлөлт оруулна. Уг асуудал нь ТӨБЗГ-аас хамаарахгүй байна. (ХБ/УБ)

		тусгасан байх; - Холбогдох хууль, журамд нийцүүлсэн эсэх; - Батлуулах арга хэмжээ авсан эсэх.	мөрдөж байгаа; - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль шинэчлэн батлагдсан нөхцөлд журамд өөрчлөлт оруулна.	боловсруулсан төслийг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна; - Журмын төслийг батлуулж, мөрдүүлсэн байна.		
Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлэн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хяналтыг сайжруулна.						
Зорилт 2. **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, менежмент, компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлнэ.**	**169.2 сая**	- **Компанийн засаглалын үнэлгээний хувь;** - **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн цэвэр ашиг, алдагдал, тэрбум төгрөгөөр;** - **Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, тэрбум төгрөгөөр.**	- **Компанийн засаглалын дундаж үнэлгээ - 53.9 хувь;** - **Цэвэр ашиг – 1,594.0 тэрбум төгрөг (2019 он);** - **Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, ногдол ашиг – 2 их наяд төгрөг (2019 он)**	- **Компанийн засаглалын үнэлгээ – 65.0 хувь;** - **Цэвэр ашиг – 1,131.6 тэрбум төгрөг (2020 он);** - **Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, ногдол ашиг – ..... төгрөг (2020 он).**	**I-IY улирал,** **ТӨУЗХ**	**Компанийн засаглалыг сайжруулах асуудлаар судалгаа болон үнэлгээ хийх чиглэлээр Санхүү, эдийн засгийн их сургууль, "Компанийн засаглалын хөгжлийн төв" ТББ-тай хамтран ажилласан.** **Компанийн засаглалын дундаж үнэлгээ 64.8 хувьд хүрсэн.** **2021 онд төсвийн тухай хуулиар хүлээсэн 183.0 тэрбум төгрөг төвлөрүүлэх үүргээ бүрэн хэрэгжүүлж, нийт 209.3 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна.** **(91.3 хувь)**
Арга хэмжээ 2.1. **(10)** Компанийн засаглалын олон улсын нийтлэг шаардлага, туршлагыг судлах	10.6 сая	- Олон улсын туршлага, нийтлэг шаардлагыг судлах	Компанийн засаглалын үнэлгээг төрийн өмчит 10 хуулийн этгээдэд	- Холбогдох төрийн бус байгууллагатай хамтран компанийн	II-IY улирал, ТӨУЗХ	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Дэлхийн банк, Европийн сэргээн босголт хөгжлийн банкны Монгол дахь төлөөлөгчтэй уулзалт

		асуудлаар холбогдох төрийн бус байгууллагатай хамтран ажиллах; - Шаардлагатай судалгаа хийж, санал, дүгнэлт гаргах; - Компанийн засаглалыг сайжруулах сайн туршлагыг нэвтрүүлэхэд бэлтгэх арга хэмжээ авсан байх.	хийсэн. Дундаж үнэлгээ – 53.9 хувь; Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.	засаглалын туршлагыг судлах чиглэлээр ажилласан байна; - Судалгаа хийж, санал, дүгнэлт гарган хэлэлцүүлсэн байна; - Компанийн засаглалын сайн туршлагыг нэвтрүүлэх бэлтгэл хангах ажлыг төлөвлөсөн байна.		хийж, зөвлөмж, арга зүйн зөвлөгөө авч, холбогдох судалгаа мэдээллийг хүргүүлэн хамтран ажилласан. Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, “Компанийн Засаглалын хөгжлийн төв” ТББ-тай хамтран “Монгол шуудан” ХК /73%/, “Монголын цахилгаан холбоо” ХК /62%/, “Монголын төмөр зам” ТӨХК /59%/, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК /60,5%/, “Амгалан дулааны станц” ТӨХК /52,6%/, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК /61,9%/, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК /84,6%/ зэрэг төрийн өмчит 7 компанийн засаглалын үнэлгээг хийлгэсэн. Мөн “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, бие даасан байдлыг сайжруулах аргууд”, “Төрийн өмчит компанид нэгдмэл тайлагналыг нэвтрүүлэх арга зам”, “Төрийн өмчит компаниудын дотоод хяналтын тогтолцоог үнэлж, сайжруулах арга зам” зэрэг компанийн засаглалын шалгуур, шаардлагатай холбоотой тодорхой сэдвээр Санхүү, эдийн засгийн их сургууль болон “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ-тай хамтран судалгаа хийсэн. Дэлхийн банкны техникийн зөвлөмжийн дагуу Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газруудын өмчлөлийн хэлбэр, засаглалыг сайжруулах загвар төслийг боловсруулсан. Тус загвар төслийг компанийн засаглалын талаарх олон улсын сайн туршлагыг Монгол Улсын өнөөгийн нийгэм, эдийн засгийн онцлогт нийцүүлэх байдлаар боловсруулсан ба зөвлөмжийн дагуу манай улс төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газруудыг төвлөрсөн, нэгдмэл удирдлагаар хангах байдлаар хэрэгжүүлэх нь оновчтой гэж үзсэн. Үүний үр дүнд, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын хараат бус байдлыг хангах, сонгон

						шалгаруулалт нээлттэй болж мэргэжлийн удирдлагаар хангах, гэрээний үр дүнг дүгнэх нээлттэй системийг нэвтрүүлэх, хяналт, шалгалтын оновчтой тогтолцоо бүрдэх, олон нийтэд ил тод нээлттэй тайлагналын нэгдсэн механизм бий болж сайн засаглалтай болно. Мөн санхүү, төсвийн сахилга бат сайжрах, хөрөнгө оруулалт, хөрөнгийн менежментийг оновчтой хийх нөхцөл бүрдэх юм. (100 хувь)
Арга хэмжээ 2.2. **(11)** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн үйл ажиллагаанд хяналт тавих	10.6 сая	- ТУЗ-д болон төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж байгаа гишүүдэд өгсөн удирдамжийн хэрэгжилт, хувиар; - ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэсэн байх; - ТУЗ-ийн чадавхыг сайжруулах ажлыг зохион байгуулсан байх; - Төрийн өмчит компаниудын Хувьцаа эзэмшигчдийн хуралд төлөөлөл хэрэгжүүлэх.	2020 онд: Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани 51 компанийн 39 ТУЗ-д 347 гишүүн ажилласан, үүнээс 111 нь хараат бус гишүүн, 236 нь төрийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүн ажилласан. 39 ТУЗ-д 186 асуудлаар 89 удирдамж өгсөн.	- Төрийн өмчит 51 компанийн 39 ТУЗ, төрийн өмчит 21 үйлдвэрийн газарт төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж, тухай бүр удирдамж, чиглэлээр хангаж, хяналт тавин ажилласан байна; - Удирдамж, чиглэл, үүрэг даалгаврын биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцсон байна; - ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэсэн байна;	I-IY улирал, ТӨУЗХ	Төрийн өмчит 51 компанийн 39 ТУЗ, төрийн өмчит 21 үйлдвэрийн газарт төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж, тухай бүр удирдамж, чиглэлээр хангаж, албан даалгавар хүргүүлэн хяналт тавин ажилласан байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай асуудлыг Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, 59 дүгээр тэмдэглэл гарсан бөгөөд энэхүү асуудлаар Засгийн газрын тогтоол гаргахаар шийдвэрлэсэн. (90 хувь)

				- ТУЗ-ийн чадавхыг сайжруулах ажил зохион байгуулсан байна; - Хувьцаа эзэмшигчийн эрхийг батлагдсан удирдамжийн дагуу хэрэгжүүлсэн байна.		
Арга хэмжээ 2.3. **(12)** Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх	106.0 сая	- Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байх; - Гүйцэтгэх удирдлагатай контракт байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт тавих, дүгнэх ажлыг зохион байгуулсан байх; - Холбогдох хууль, журамд нийцсэн байх.	2020 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 24 компани, 21 төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, 45 захирлын контрактын биелэлтийг дүгнэсэн. 42 захиралтай байгуулсан контрактыг сунгасан, 3 захирлын	- Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний болон хөрөнгө оруулалтын 2020 оны төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэх удирдлагын контрактыг дүгнэж, үр дүнг тооцсон байна; - 2021 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэх удирдлагын контрактын хэрэгжилт, үйл ажиллагааны явцад хяналт тавьсан байна; - Эдийн засгийн	I-IY улирал, ТӨУЗХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж ажилласан болон Сангийн яам, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөл хэрэгжүүлдэг нийт 101 хуулийн этгээдийн 2020 оны жилийн эцсийн тайлан тэнцлийн дүн болон 2011-2020 оны үр ашиг, татвар хураамжийн үзүүлэлтийг нэгтгэн гаргаж, УИХ, ЗГ-ын гишүүд болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудын удирдлагуудад хүргүүлсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, захирлуудын контрактын биелэлтийг дүгнэсэн. Төрийн өмчийн оролцоотой компаниудын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон захирлын контрактын биелэлтийг Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулсан.

			контрактын биелэлтийг хангалтгүй гэж дүгнэж холбогдох арга хэмжээ авсан.	үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын 2021 оны төлөвлөгөөг тодотгох, 2022 оны төлөвлөгөөг хянан батлах ажлыг зохион байгуулсан байна; - ТӨБЗГ-ын хуралдаанд холбогдох асуудлыг танилцуулж, шийдвэр гаргуулсан байна.		Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар захирлуудын контрактыг сунгах эсэх асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, контрактын гэрээнүүдийг 1 жилээр сунгаж, контрактыг шинэчлэн байгуулсан. (100 хувь)
Арга хэмжээ 2.4. **(13)** Шинээр болон өөрчлөн байгуулагдсан төрийн өмчит хуулийн этгээдийн дүрэм батлах, зохион байгуулалтын бүтцийн асуудлыг судлан шийдвэрлүүлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах	7.0 сая	- Төрийн өмчит хуулийн этгээдийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг судлан боловсруулж, батлуулсан байх.	2020 онд төрийн өмчит 4 хуулийн этгээдийн дүрмийн төслийг боловсруулж, ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулан батлуулсан.	- Хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан байна; - Холбогдох байгууллагын саналыг авч, тусгасан байна; - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны шийдвэрээр батлуулж, хэрэгжилтийг хангуулсан байна.	I-IY улирал, ТӨУЗХ	Монгол Улсын Засгийн газар болон холбогдох яамдаас өгсөн чиглэл, санал, зөвлөмжийн хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар шинээр болон өөрчлөн байгуулагдсан төрийн өмчит хуулийн этгээдийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн тогтоох асуудлуудыг шийдвэрлэсэн. Үүнд: “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах, “Геологийн төв лаборатори” ТӨҮГ, “Геологийн судалгааны төв” ТӨҮГ-ын дүрмийг тус тус шинэчлэх, “Багануур АЗЗА” ТӨХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах, “Монголросцветмет” ТӨҮГ-ын орон тооны дээд хязгаарыг шинэчлэх, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын бүтцийг өөрчлөх, “Замын-Үүдийн дулааны станц” ТӨҮГ-ын дүрэм, бүтцэд өөрчлөлт оруулах гэх мэт. (100 хувь)

Арга хэмжээ 2.5. **(14)** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн нэгтгэлд дүн шинжилгээ хийж, товхимол, гарын авлага гаргах	7.0 сая	- Санхүү, эдийн засгийн үзүүлэлтийн дүн мэдээг хуулийн этгээд бүрээр цуглуулж нэгтгэсэн байх; - Дүн шинжилгээ хийж, нэгдсэн танилцуулга, мэдээлэл бэлтгэсэн байх; - Албан хэрэгцээнд зориулж товхимол, гарын авлага бэлтгэж хэвлүүлсэн эсэх.	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2019 оны санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг нэгтгэж, 150 ширхэг товхимол хэвлүүлэн сурталчилсан.	- Санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг нэгтгэж, дүн шинжилгээ хийсэн байна; - Товхимол хэвлүүлж, тараасан байна.	II улирал, ТӨУЗХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж ажилласан болон Сангийн яам, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөл хэрэгжүүлдэг нийт 101 хуулийн этгээдийн 2020 оны жилийн эцсийн тайлан тэнцлийн дүн болон 2011-2020 оны үр ашиг, татвар хураамжийн үзүүлэлтийг нэгтгэн гаргаж, УИХ, ЗГ-ын гишүүд болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудын удирдлагуудад хүргүүлсэн. (100 хувь)
Арга хэмжээ 2.6. (15) Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хөгжлийн төлөвлөлтийг тодорхой болгоход чиглэсэн арга зүйгээр хангах	7.0 сая	- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн урт болон дунд хугацааны бизнес төлөвлөгөө боловсруулах чадавхыг сайжруулсан байх.	Хуулийн этгээдэд урт болон дунд хугацааны бизнес (хөгжлийн) төлөвлөгөө байхгүй. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд	- Хөгжлийн төлөвлөлтийг оновчтой хийх талаар мэргэжил, арга зүйн удирдлага, чиглэлээр хангасан байна; - 2-3 хуулийн этгээдэд бизнес төлөвлөгөө боловсруула-хад бэлтгэж,	I-IV улирал, ТӨУЗХ	Хөгжлийн төлөвлөлтийг оновчтой хийх ажлын хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн урт болон дунд хугацааны бизнес төлөвлөгөө боловсруулах, чадавхыг сайжруулах чиглэлээр тодорхой судалгаа, бэлтгэл ажил хийгдэж байна. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Монголросцветмет” ТӨҮГ зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд урт болон дунд хугацааны бизнес төлөвлөгөө, чиглэлийг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. (100 хувь)

			тусгагдсан.	үнэлгээ, судалгаа шинжилгээ хийгдсэн байна.		
Арга хэмжээ 2.7. (16) Төрийн өмчит хуулийн этгээдийн цахим мэдээллийн сан үүсгэх	7.0 сая	- Цахим мэдээллийн санд оруулах мэдээллийн агуулга, ангиллыг тодорхой болгосон байх; - Цахим санд мэдээлэл нь орсон төрийн өмчит хуулийн этгээдийн тоо.	Цахим мэдээллийн нэгдсэн сан байхгүй	- Төрийн өмчит хуулийн этгээдийн цахим мэдээллийн санд оруулах мэдээллийг ангилан нэгтгэсэн байна; - Цахим мэдээллийн сан үүссэн байна.	II улирал, ТӨУЗХ	Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн цахим мэдээллийн сан бий болгох, мэдээллүүдийг ангилан нэгтгэх талаар холбогдох судалгаа, тооцооллыг хийж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. (50 хувь)
Арга хэмжээ 2.8. (17) Нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах замаар хувьчлахаар шийдвэрлэсэн үл хөдлөх хөрөнгийг худалдах, хувьчлах ажлыг зохион байгуулах	7.0 сая	- Засгийн газрын шийдвэр гарсан байх; - Дуудлага худалдааг нээлттэй хэлбэрээр, хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байх; - Орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байх; - Холбогдох тайлан,	2020 онд дуудлага худалдаа зохион байгуулагдаагүй.	- Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна; - Худалдах, худалдан авах гэрээ байгуулсан байна; - Өмчлөх эрхийг шилжүүлэн, үл хөдлөх хөрөнгийг шинэ өмчлөгчид хүлээлгэн өгсөн байна.	I-IY улирал, тухай бүрд, ТӨУЗХ	Төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай Засгийн газрын тогтоол шийдвэр гараагүй. (ХБ/ҮБ)

		мэдээллийг нэгтгэсэн байх.		- Хувьчлалын тайланг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулж, мэдээлсэн байна.		
Арга хэмжээ 2.9. (18) Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах	7.0 сая	- 2020 онд ашигтай ажилласан хуулийн этгээдийн төрийн өмчийн ногдол ашгийн хувь, хэмжээг тогтоосон байх; - Ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлтийн хувь; - Засгийн газар, Сангийн яаманд сар бүр тайлагнасан байх.	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар батлагдсаны дагуу 173.0 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласан байна. Үүнээс Ирээдүйн өв санд 155.0 тэрбум төгрөгийн орлого, улсын төсөвт 18.2 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашгийн орлого төвлөрүүлнэ. Төлөвлөгөөний биелэлт; 172.4 төгрөг буюу 99.3 хувь байна.	- ТӨБЗГ-ын тогтоолоор төрийн өмчийн ногдол ашгийн хувь, хэмжээг тогтоосон байна; - Ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьсан байна; - Улсын төсөвт төвлөрүүлэх нийт ногдол ашгийн орлого 183.0 тэрбум төгрөг, үүнээс Ирээдүйн өв санд 155.0 тэрбум төгрөг, хувьцааны ногдол ашиг 28.0 тэрбум төгрөг; - Төлөвлөгөөний биелэлт 100 хувь; - Орлогын төлөвлөгөөний биелэлтийг сар бүр тооцоо нийлж, тайлагнасан байна.	II-IY улирал, ТӨУЗХ, ЗУХ	Төсвийн тухай хуулиар хүлээсэн төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлэх үүргээ хэрэгжүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд төрийн өмчийн ногдол ашиг төвлөрүүлэх хувь хэмжээг тогтоох асуудлыг боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулалтаар хангаж, хяналт тавин ажилласны үр дүнд 2021 онд Төсвийн тухай хуулиар хүлээсэн 183.0 тэрбум төгрөг төвлөрүүлэх үүргээ бүрэн хэрэгжүүлж, нийт 209.3 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна. 2021 оны 12 дугаар сарын 25-ны дотор “Улаанбаатар төмөр зам” ХНН 1.1 тэрбум төгрөг, “Эрдэнэс Монгол” ХХК 0.7 тэрбум төгрөг, “Төрийн банк” ХХК 3.0 тэрбум төгрөг, “Үндэсний давхар даатгал” ХХК 0.3 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлэхэд анхаарал хандуулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийг сар бүр Төсвийн ерөнхийлөн захирагч болон Сангийн яаманд тайлагнан ажиллав. (90 хувь)

Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Төрийн өмчийн орон сууц хувьчлах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангана.						
Зорилт 3. **Төрийн өмчийн орон сууц хувьчлах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.**	**21.2 сая**	- **Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, хувиар;** - **Хувьчлалд хамрагдсан орон сууц, тоогоор.**	**Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам мөрдөгдөж байгаа;** **Хууль тогтоомжийн хэрэгжилт 90< хувь.**	- **Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт 100 хувь;** - **Хувьчлалын ажлыг тухай бүр хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна.**	**I-IV улирал,** **ТӨУЗХ**	**Нийт 135 айлын орон сууцыг одоо эзэмшиж байгаа иргэдэд нь хувьчлах асуудлыг шийдвэрлүүлж, хувьчлалыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан.** **21 айлын орон сууцыг хувьчлах асуудлыг шийдвэрлүүлэхээр ЗГХЭГ-т холбогдох материалыг хүргүүлсэн байна.** **(100 хувь)**
Арга хэмжээ 3.1. (19) Төрийн өмчийн орон сууц хувьчлах ажлыг зохион байгуулах	21.2 сая	- Холбогдох байгууллагын хүсэлтийг судалж, авах арга хэмжээний саналыг боловсруулах; - Засгийн газрын шийдвэрийн дагуу хувьчлах ажлыг зохион байгуулсан байх; - Орон сууц хувьчлах товчоодыг арга зүйн удирдлагаар хангасан байх.	ХХААХҮЯ-ны харьяа 9 айлын орон сууцыг хувьчлах тухай Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангасан. Дархан-Уул, Орхон аймгийн Орон сууц хувьчлах товчоонд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлсэн.	- Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тухай бүрд зохион байгуулсан байна. - Орон сууц хувьчлах товчоодын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлсэн байна.	I-IV улирал, ТӨУЗХ	“Монголросцветмет” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд орших угсармал төмөр хийц бүхий 83 айлын орон сууц, модон хийц бүхий 22 айлын орон сууц, тоосгон хийц бүхий 16 айлын орон сууц, Дорноговь аймгийн Өргөн суманд орших 14 айлын орон сууц, нийт 135 айлын орон сууцыг одоо эзэмшиж байгаа албан хаагчдад нь хувьчлах асуудлыг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцээд дэмжиж, Орон сууц хувьчлах тухай хуулийн 6.3 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлэхээр тэмдэглэл гаргасан. Уг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 2021 оны 304 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 1 дүгээр хороллын Москва гудамжинд байрлалтай 44 дүгээр байрны 21 айлын орон сууцыг одоо амьдарч байгаа албан хаагчдад нь хувьчлах асуудлыг ТӨБЗГ-ын 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд дэмжиж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр тогтсон тул ЗГХЭГ-т

						2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А-1/1793 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна. (100 хувь)
Стратеги төлөвлөгөөний зорилго 4. Орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдамж, чиглэлээр хангаж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.						
Зорилт 4 **Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад орон нутгийн өмчийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.**	**21.2 сая**	- **Хуульд нийцсэн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байх;** - **Чадавх сайжруулах арга хэмжээг авч, хамтран ажилласан байх.**	**Орон нутгийн удирдлага, өмчийн байгууллагад тухай бүр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн.**	- **Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна;** - **Орон нутгийн өмчийн удирдлагын чадавх сайжирсан байна.**	**I-IV улирал,** **ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, ЗУХ, ХЭЗХ**	**Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Орхон, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар, иргэд орон нутгийн өмчит хуулийн этгээдэд компанийн засаглал болон орон нутгийн өмчийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.** **4 аймгийн Орон нутгийн өмчийн газарт хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, эрх зүйн туслалцаа үзүүлсэн байна.** **5 аймгийн хувьчлах орон нутгийн өмчийн эд хөрөнгийн жагсаалтыг зөвшилцөх асуудлыг судлан шийдвэрлэсэн. (100 хувь)**
Арга хэмжээ 4.1. (20) Орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг зөвшилцөх асуудлыг судлан шийдвэрлүүлэх	10.6 сая	- Орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг зөвшилцөхөөр ирүүлсэн саналыг судлах; - Холбогдох санал боловсруулж, ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүл-сэн байх.	Дархан-Уул, Архангай аймгаас хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг зөвшилцсөн.	Орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг зөвшилцсөн асуудлаар хуульд нийцсэн шийдвэр гаргуулж, тухайн орон нутгийн удирдлагад хүргүүлсэн байна.	I-IV улирал, ТӨУЗХ	Баянхонгор, Төв, Хөвсгөл, Орхон, Говь-Алтай зэрэг аймгийн хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг зөвшилцөн хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан. (100 хувь)
Арга хэмжээ 4.2. (21) Төрийн болон орон нутгийн өмчийн	10.6 сая	- Мэргэжил, арга зүйн удирдлага, зөвлөгөө,	Өвөрхангай, Орхон, Хөвсгөл, Ховд аймгийн Орон нутгийн	- Орон нутгийн удирдлага, орон нутгийн өмчийн	I-IV улирал, ТӨУЗХ,	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн үзэл баримтлалын талаар танилцуулах, тухайн

харилцаа, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн компанийн засаглалын асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх		дэмжлэгээр хангасан байх.	өмчийн газарт зөвлөгөө өгч хамтран ажилласан.	байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, нэгдсэн удирдамж, арга зүйн дэмжлэгээр хангасан байна.	ТӨБАХ, ТӨХШХ, ЗУХ, ХЭЗХ	байгууллагуудын үйл ажиллагаа, бүтээн байгуулалт, тулгамдаж буй асуудлуудтай танилцах, компанийн засаглал, төрийн болон орон нутгийн өмчийн асуудлаар арга зүйн зөвлөгөө өгөх, 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийн талаар санал солилцох зорилгоор Нийслэлийн зарим дүүрэг болон Дорноговь, Хэнтий, Сүхбаатар, Орхон, Хөвсгөл, Булган, Архангай, Өвөрхангай, Төв зэрэг аймагт ТӨБЗГ-ын ТӨУЗХ-ийн албан хаагчдыг ажиллуулав. Мөн “Геологийн төв лаборатори” ТӨҮГ, “Геологийн судалгааны төв” ТӨҮГ, “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ХХК, “Нью Улаанбаатар эйрпорт” ХХК, “МИАТ” ТӨХК, “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, “Барилга хөгжлийн төв” ТӨҮГ, “Төрийн орон сууцны корпораци” ХХК, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн бүтээн байгуулалтын ажилтай газар дээр нь очиж танилцаж, мэдээлэл солилцон, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллав. “Дорноговь АЗЗА” ТӨХК, “Багануур АЗЗА” ТӨХК, “Багануурын дулааны станц” ТӨХК, “Багануур, зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК, “Харгуй” ТӨХК, “Талын зам” ТӨХК, “Эрдэнэсант АЗЗА” ТӨХК, “Хархорин АЗЗА” ТӨХК, “Архангай АЗЗА” ТӨХК, “Завхан АЗЗА” ТӨХК, “Булган АЗЗА” ТӨХК, “Хөвсгөл АЗЗА” ТӨХК, “Орхон АЗЗА” ТӨХК, “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцаж, холбогдох зөвлөмж өгч, тулгамдсан зарим асуудлуудыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авсан. Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой асуудлаар Орон нутгийн өмчийн газрын албан хаагчдад эрх зүйн сургалт хийж, зөвлөгөө, аргазүйгээр хангаж ажиллав. Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газарт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын эрх

						хэмжээний хүрээ, зааг ялгааны талаар, Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газарт үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилгыг тогтоол шийдвэргүйгээр буулгасан асуудлаар, Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газарт сувиллын барилгуудыг нээлттэй дуудлага худалдаагаар худалдах доод үнэ тогтоох асуудлаар тус тус хууль эрх зүйн тайлбар, зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлсэн байна. (100 хувь)
Стратеги төлөвлөгөөний зорилго 5. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах, Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулах бүтээн байгуулалтын үе шатны ажлуудыг хэрэгжүүлнэ.						
Зорилт 5. **"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.**	**21.2 сая**	**Үйлдвэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн байх, хувиар**	**“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг хөгжүүлэх үндсэн чиглэл, 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үе шатны ажлыг тусгасан.**	- **Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явц 7.5 хувь;** - **Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явц 50.0 хувь.**	**I-IV улирал,** **ТӨУЗХ**	**“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах “Уул уурхай - Металлурги - Химийн үйлдвэрийн цогцолбор” ҮТП-ийн бүтээн байгуулалтын үе шатны ажлууд хэвийн явагдаж, ахицтай байна. Үүнд:** – **Судалгаа, үнэлгээний ажлууд хийгдсэн байна;** – **Тусгай зөвшөөрлийн асуудал шийдвэрлэгдсэн;** – **ҮТП-ийн удирдлагатай гэрээ байгуулсан;** – **Газрын асуудлыг шийдвэрлэсэн;** – **Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт хангагдаж дээрх үр дүнгүүд гарч байна.** **(100 хувь)**
Арга хэмжээ 5.1. (22) “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах, Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулах	21.2 сая	- Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тодотгол хийгдсэн эсэх; - Исэлдсэн хүдрийг нуруулдан	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг хөгжүүлэх үндсэн чиглэл, 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан.	- Бүтээн байгуулалтын төслүүдийг эхлүүлсэн байна; - “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	I-IV улирал, ТӨУЗХ	Бүтээн байгуулалтын ажилтай холбоотой дараах зохион байгуулалт, судалгаа, үнэлгээний үе шат бүхий ажлууд хийгдээд байна. Үүнд: “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн “Уул уурхай - Металлурги - Химийн үйлдвэрийн цогцолбор” ҮТП байгуулах нарийвчилсан ТЭЗҮ, паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг “Эрдэнэс үндэсний судалгаа хөгжлийн төв” ХХК, “Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн” ТББ-ын хамтарсан консорциумаар гүйцэтгүүлсэн.

бэлтгэл хангах		уусгах үйлдвэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн эсэх.		биелсэн байна.		ҮТП-ийн Техник технологийн түвшний үнэлгээ, нутаг дэвсгэрийн геоэкологийн суурь судалгааны ажил, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ зэргийг холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн. “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 10.2-т заасан баримт бичгүүдийг боловсруулж дууссан. Засгийн газрын 2021 оны 129 дүгээр тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгох асуудлыг шийдвэрлэсэн. УУХҮЯ болон тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хооронд 2021 оны 6-р сарын 22-ны өдөр 5/159-21 дугаартай ҮТП-ийн удирдлагатай байгуулах гэрээ байгуулан ажиллаж байна. ҮТП байгуулах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Орхон аймгийн ИТХ-аар хэлэлцүүлсэн. Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зорилгоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын одоо эзэмшиж буй 871.4 га, Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрээс 175.4 га, Жаргалант сумын нутаг дэвсгэрээс 170.6 га, нийт 1,217.4 га талбайг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг дэмжиж, 2021 оны 7-р сарын 1-ний өдрийн Орхон аймгийн ИТХ-ын 14 дүгээр тогтоол гарсан байна. ҮТП-ийн дэд бүтэц барьж байгуулах суурь судалгаа, инженер геологи, хөрсний судалгааг “Инж геотех” ХХК гүйцэтгэж байна. Тус компани ҮТП байгуулах талбайд өрөмдлөг, дээжлэлт, туршилт хэмжилтийн ажлуудаа бүрэн хийж дууссан бөгөөд тайлан боловсруулалтын ажил хийгдэж байна. Гэрээний хугацаа 2021 оны 12-р сард дуусах бөгөөд гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2021 оны хөрөнгө

						оруулалтын төлөвлөгөөнд ҮТП-ийн дэд бүтцийг барьж байгуулах ажлын төсөвт өртгийг 47.7 сая ам.доллароор тусган ТӨБЗГ-ын тогтоолоор батлуулсан ба ҮТП-ийн дэд бүтцийг барьж байгуулах инженерийн зураг төслийн болон бусад бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. (100 хувь)
Стратеги төлөвлөгөөний зорилго 6. Орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн хэрэгжүүлэхэд чиглэсэн “Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” ХХК-ийг шинээр байгуулна.						
Зорилт 6. **“Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.**	**21.2 сая**	- **Хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн эсэх;** - **Холбогдох судалгаа, тооцооллыг хийсэн байх.**	**Тооцоо судалгаа, шийдвэр гараагүй. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.**	- **“Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци”-ийг байгуулах эрх зүйн орчин тодорхой болсон байна.**	**II, III улирал,** **ТӨУЗХ**	**Зохион байгуулалтын арга хэмжээ авсан, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэр гарах хүртэл хүлээгдэж байна.** **(50 хувь)**
Арга хэмжээ 6.1. (23) “Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” ХХК-ийг байгуулах асуудлыг судлан боловсруулах, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах	21.2 сая	- Холбогдох тооцоо, судалгааг гаргаж, үндэслэлийг тодорхой болгосон байх; - Корпорацийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийн талаар санал боловсруулж, батлуулах арга хэмжээ авсан байх.	Тооцоо судалгаа, шийдвэр гараагүй, ямар нэг ажил хийгдээгүй	- Корпорацийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийн асуудлыг судалгаа, тооцоололд үндэслэн шийдвэрлэж, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна; - “Төрийн орон сууцны корпораци” ХХК, “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-	II, III улирал, ТӨУЗХ	Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК болон “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийг нийлүүлэх замаар өөрчлөн зохион байгуулж төрийн өмч давамгайлсан (жаран зургаан хувиас доошгүй) “Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай асуудлыг хэлэлцээд Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл гаргасан. Уг тэмдэглэлийг хэрэгжүүлэх хүрээнд Барилга, хот байгуулалтын сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагууд 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдөр нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалан, Нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Сандагсүрэн болон бусад холбогдох албаны хүмүүстэй уулзалт хийсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/534 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын

				ийн бие даасан үйл ажиллагааг зогсоож, “Үндэсний орон сууцны корпораци” ХХК-д нэгтгэн зохион байгуулах.		захирагч Д.Сумьяабазарт хамтран ажиллах тухай хүсэлт хүргүүлсэн. Дээрх авч хэрэгжүүлсэн зохион байгуулалтын арга хэмжээний дүнд “Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” ХХК байгуулах асуудлыг 2021 оны 04 сарын 29-ний өдрийн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийг татан буулгах, шинэ байгууллагад нэгтгэх талаар Ажлын хэсгийн дүгнэлт гаргахаар шийдвэрлэсэн байна. Өнөөдрийн байдлаар ямар нэгэн эцсийн шийдвэр гараагүй байгаа болно. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК нь шинээр байгуулагдах байгууллагын дүрэм, байгууллагын бүтэц, бүрэлдэхүүний талаар Барилга, хот байгуулалтын яамтай хамтран тодорхой саналуудыг гаргаад байна. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал хуралдаж шийдвэр гаргасны дараа “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн ТУЗ энэхүү асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргахаар хүлээгдэж байна. (50 хувь)
Стратеги төлөвлөгөөний зорилго 7. Төрийн өмчид бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлж, өмчийн эзэмшилт, ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлнэ.						
Зорилт 7. **Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлж, хариуцлагыг сайжруулна.**	**107.6 сая**	- **Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллого зохион байгуулсан байх;** - **“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний биелэлтэд дүн**	- **Үзлэг, тооллогыг 2021 онд зохион байгуулах асуудлаар Засгийн газрын шийдвэр гарсан.** - **“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний**	- **Улсын үзлэг, тооллогыг зохион байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулж, авах арга хэмжээний талаар шийдвэр гаргуулсан байна;** - **“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2020 оны биелэлт 4**	**I-IY улирал,** **ТӨБАХ**	**Улсын үзлэг, тооллогыг 2022 онд зохион байгуулахаар хойшлуулж, Засгийн газрын 2021 оны 278 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн бөгөөд шаардлагатай төсөв хөрөнгийн асуудал 2022 оны улсын төсөвт тусгагдсан.** **Гэрээний дундаж дүн 93.03 хувьтай байгаа нь өнгөрсөн оныхоос 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.** **(100 хувь)**

		шинжилгээ хийж, авах арга хэмжээний үр нөлөөг сайжруулах.	**2016-2019 оны биелэлтийн улсын дундаж үнэлгээ 91.9 хувь.**	**жилийн дунджаас ахисан үзүүлэлттэй байна.**		
Арга хэмжээ 7.1. (24) Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого зохион байгуулах	64.6 сая	- Улсын үзлэг, тооллого зохион байгуулагдсан эсэх; - Дүн, нэгтгэлийг боловсруулж, Засгийн газарт танилцуулсан эсэх; - Үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээг тодорхойлон холбогдох шийдвэр гаргуулсан байх.	- 2016 онд улсын үзлэг тооллогыг зохион байгуулж байсан. - Засгийн газрын 2020 оны 46 дугаар тогтоолоор 2021 онд зохион байгуулах шийдвэр гарсан. - Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.	- Шаардлагатай зардлын асуудлыг шийдвэрлүүлж, бэлтгэл ажил, зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна; - Улсын үзлэг, тооллогыг зохион байгуулж, дүнг нэгтгэн ТӨБЗГ-т танилцуулж, ЗГХЭГ-т тайлагнана - Үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	II-IY Улирал, ТӨБАХ	Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг 2021 онд багтаан явуулахаар шийдвэрлэн боловч цар тахлын нөхцөл байдлын улмаас уг шийдвэрт 2 удаа өөрчлөлт оруулан хугацааг хойшлуулсан. Мөн уг улсын үзлэг тооллогод шаардлагатай төсөв батлагдаагүй байсан тул ТӨБЗГ-аас тооллогын асуудлыг Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 278 дугаар тогтоолоор хугацааг хойшлуулж, 2022 онд зохион байгуулахаар тогтсон. Монгол Улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг зохион байгуулах асуудал тусгагдаж, шаардлагатай хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Бэлтгэл ажлыг хангах хүрээнд нийслэл, 21 аймгийн Засаг дарга нарт 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А-1/1510 дугаар албан бичгээр улсын үзлэг, тооллого зохион байгуулахтай холбогдуулан Засгийн газрын 2021 оны 278 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах тухай чиглэлийг хүргүүлсэн. (100 хувь)
Арга хэмжээ 7.2. (25) Аймаг, нийслэл, орон нутаг дахь төрийн өмчит хуулийн этгээдтэй байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2020 оны биелэлтийг	43.0 сая	- “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний биелэлтийг дүгнэх, гэрээг шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулсан	- 2020 онд төрийн өмчит 961 хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний улсын дундаж үнэлгээ 94.1 хувь; - Гэрээний	- “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэсэн байна; - Гэрээний хэрэгжилтийн улсын дундаж 91.9< хувь	I-IY улирал, ТӨБАХ	Дэлхий нийтэд тархсан цар тахлын үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/1160 дугаар албан бичгийг төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэн чиглэл өгч, “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт хамгаалалтад хяналт тавих журам”-ын дагуу “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г 2021 онд шинэчлэн байгуулах, 2020 оны гэрээний биелэлтийг дүгнэх ажлыг цахим хэлбэрээр зохион

дүгнэж, 2021 оны гэрээг шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулах		байх; - Гэрээний тоо, хэрэгжилтийн улсын дундаж хувь; - Гэрээний хэрэгжилтийн дүнд дүгнэлт хийж, авах арга хэмжээг тодорхойлсон байх.	дүнгийн мөрөөр авах арга хэмжээг тодорхойлж, холбогдох зөвлөмжийг төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлсэн.	байна (4 жилийн дундаж үнэлгээ); - Төрийн өмчит 900 хуулийн этгээдтэй “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г шинэчлэн байгуулсан байна; - Дүн, дүгнэлтийн мөрөөр авах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлсэн байна.		байгуулав. Энэ хүрээнд холбогдох баримт материалыг цахимаар хүлээн авч, 2020 оны гэрээний биелэлтийг дүгнэсэн. 2021 онд 985 хуулийн этгээдтэй “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” байгуулсан. Тайлант онд эрх бүхий байгууллагын шийдвэрээр 5 хуулийн этгээд шинээр бий болсон байна. “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2020 оны улсын дундаж дүн 93.03 хувьтай байгаа нь өнгөрсөн оныхоос 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. (100 хувь)
Зорилт 8. **Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэн төсвийн орлогыг бүрдүүлж, зардлыг бууруулна.**	**36.9 сая**	**- Төрийн өөрийн өмчийн түрээс орлогын төлөвлөгөө-ний биелэлтийг хангах, тэрбум төгрөгөөр;** **- Төрийн өмчийн ашиглалтын зардлыг бууруулах арга хэмжээ авсан байх.**	**Төрийн өмчийн ашиглалтын зардлыг бууруулах хүрээнд авсан арга хэмжээний дүнд улсын төсөвт 2.75 тэрбум төгрөгийн орлого оруулсан байна.**	**Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалттай холбоотой 1.7 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ:** **- Төрийн өөрийн өмчийн түрээс орлого 1.6 тэрбум төгрөг;** **- Дуудлага худалдаанаас 100.0 сая төгрөг.**	**I-IV улирал,** **ТӨБАХ**	**Төрийн өмчийн илүүдэлтэй байр, талбайг түрээслүүлсний орлогоос 40 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан хяналт тавих ажлын хүрээнд өссөн дүнгээр нийт 1,711,302,888.45 төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлээд байна.** **Эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдаанаас нийт 357,483,807.72 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.** **(100 хувь)**

Арга хэмжээ 8.1. (26) Төрийн өмчит хуулийн этгээдийн түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах, сунгах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих	12.3 сая	- Төрийн өмчит хуулийн этгээдийн түрээсийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих; - Улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өөрийн өмчийн түрээсийн орлого, тэрбум төгрөгөөр; - Засгийн газар, Сангийн яаманд орлогын төлөвлөгөөний биелэлтийг тайлагнасан байх.	2020 онд 150 гаруй төрийн өмчит хуулийн этгээдийн түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах, сунгах ажлыг зохион байгуулж, 913 (давхардсан тоогоор) түрээсийн гэрээг байгуулж, 2.4 тэрбум төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн.	- 130 гаруй төрийн өмчит хуулийн этгээдийн түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах, сунгах ажлыг зохион байгуулж, хяналт тавьсан байна; - Улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өөрийн өмчийн түрээсийн орлого – 1.6 тэрбум төгрөг; - Орлогын төлөвлөгөөний биелэлтийг сар бүр тооцоо нийлж, тайлагнасан байна.	I-IV улирал, ТӨБАХ, ЗУХ	Төрийн өмчийн илүүдэлтэй байр, талбайг түрээслүүлсний орлогоос 40 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан хяналт тавих ажлын хүрээнд өссөн дүнгээр нийт 1,711,302,888.45 төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлээд байна (2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар). ТӨБЗГ-ын 2021 оны 2 дугаар тэмдэглэлээр Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасныг үндэслэн бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэн нөхцөл байдлыг харгалзан 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг сонгон шалгаруулалтгүй шинээр байгуулах, 6 сарын хугацаагаар сунгахаар шийдвэрлэсэн**.** Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан хуулийн этгээдүүдийн гэрээг сунгах, шинээр гэрээ байгуулах, тооцоо нийлэх, түрээслэх зөвшөөрөл олгох зэрэг ажлуудыг тогтмол хийж байна. (100 хувь)
Арга хэмжээ 8.2. (27) Төрийн өмчит хуулийн этгээдийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдах ажлыг зохион байгуулах	12.3 сая	- Нээлттэй дуудлагын худалдаа зохион байгуулсан байх; - ТӨБЗГ-ын шийдвэр гарсан байх; - Хуулийн этгээдийн тоо;	- 2020 онд ТӨБЗГ-ын тогтоолоор нийт 134 байгууллага (давхардсан тоогоор)-ын элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 304 нэрийн 9.9	- ТӨБЗГ-ын шийдвэрийн дагуу нээлттэй дуудлагын худалдаа зохион байгуулсан байна; - Хуулийн этгээдийн тоо – 60;	I-IV улирал, ТӨБАХ, ЗУХ	Нийт 58 байгууллагын 223 нэрийн 14.40 тэрбум төгрөгийн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах шийдвэргаргуулан ажилалаа. Эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдаанаас 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр нийт 357,483,807.72 төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. (100 хувь)

		- Худалдан борлуулсан хөрөнгийн тоо; - Улсын төсөвт төвлөрүүлсэн дуудлага худалдааны орлого, сая төгрөгөөр.	тэрбум төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг худалдах зөвшөөрөл олгосон; - Автомашины дуудлага худалдаанаас 2020 онд 375.65 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн.	- Нээлттэй дуудлагын худалдаагаар худалдаалах хөрөнгийн тоо – 80; - Улсын төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн дуудлага худалдааны орлого –100.0 сая төгрөг.		
Арга хэмжээ 8.3. (28) Төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины ашиглалтад бүртгэлээр хяналт тавьж, зардлыг бууруулах	12.3 сая	- Төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины тоо, нэр төрлийн судалгаа хийж, дүгнэлт гаргасан байх; - Суудлын автомашины талаар авах арга хэмжээний тухай санал боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байх.	2020 онд төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины тоо, төрөл, зардлын судалгааг гаргаж, ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн. ТӨБЗГ-ын шийдвэр, холбогдох санал, дүгнэлтийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Тодорхой шийдвэр гараагүй.	- Холбогдох судалгаа хийж, санал дүгнэлт гаргасан байна; - Суудлын автомашины талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын шийдвэр гарсан байна; - Хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.	I-IV улирал, ТӨБАХ	Улсын Онцгой Комиссын 2021 оны 1067 дугаар албан бичгээр ирүүлсэн Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд Гамшгаас хамгаалах хуулийн дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн нийт 54 ширхэг бага оврын автобус, фургоныг жолоочийн хамт дайчлах ажлыг зохион байгуулж, Улсын Онцгой Комиссын Шуурхай штабд хүлээлгэж өгсөн. Улсын Онцгой Комиссын Шуурхай штабын үйл ажиллагаанд төрийн өмчит хуулийн этгээдээс 15 ширхэг суудлын автомашиныг түр хугацаагаар шилжүүлж, шуурхай дуудлага, бусад шаардлагатай ажилд дайчлан ажиллуулж байна. “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн үед коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх вакцинжуулалтын үйл ажиллагаанд Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газартай хамтран төрийн болон нийслэлийн өмчийн нийт 61 автобусыг татан төвлөрүүлсэн.

						Нийт 40 автобусыг явуулын вакцинжуулалтад зориулж бэлтгэх, цэвэрлэх, тоноглох ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж Улсын Онцгой Комиссын мэдэлд хүлээлгэн өгсөн. Нийт 21 автобусыг явуулын вакцинжуулалтын үеэр ажиглалтын байр болгон ашиглах бэлтгэл ажлыг ханган УОК-ын мэдэлд шилжүүлсэн. (100 хувь)
Стратеги төлөвлөгөөний зорилго 8. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтыг оновчтой удирдлага, зохицуулалтаар хангаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулан, төрийн өмчийн бүртгэл, мэдээллийг тодорхой болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.						
Зорилт 9. **Төрийн өмчийн эзэмшилт ашиглалтын удирдлага, зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлж, өмчийн бүртгэл мэдээллийг сайжруулна.**	**49.2 сая**	**Төрийн өмчийн бүртгэл, мэдээллийн үнэн бодит байдал, холбогдох хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилтийг хангасан байх.**	**2020 онд 1810 байгууллагын эд хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн зохицуулалтын асуудлыг шийдвэрлэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санг хөтөлсөн.**	**Эд хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн асуудлыг тухай бүр судлан ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн оновчтой шийдвэр гаргуулсан байна. Бүртгэл, мэдээллийг хянан баталгаажуулж, хөтөлсөн байна.**	**I-IV улирал,** **ТӨБАХ**	**Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 444 тогтоол 5 тэмдэглэл, газрын даргын 170 албан бичгээр нийт 1270 (давхардсан тоогоор) байгууллагын 53612 нэрийн 1,915.23 тэрбум төгрөгийн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн зохицуулалтыг хийж, төрийн өмчийн бүртгэл, мэдээллийг хянан баталгаажуулсан байна.** **(100 хувь)**
Арга хэмжээ 9.1. (29) Төрийн өмчийн эд хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн асуудлыг судлан бодлогоор зохицуулах, хөрөнгийн хөдөлгөөний бүртгэл, мэдээллийн нэгдсэн	12.3 сая	- Төрийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг судлан шийдвэрлүүлэх;	Төрийн өмчит 1810 (давхардсан тоогоор) хуулийн этгээдийн 90080 нэр төрлийн 2,138.1 тэрбум төгрөгийн	- Төрийн өмчит 1000 гаруй хуулийн этгээдийн эд хөрөнгийн зохицуулалтын асуудлыг судлан санал	I-IV улирал, ТӨБАХ	Төрийн өмчит хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн санал, хүсэлтийг судлан боловсруулж, шийдвэрийн төсөл, танилцуулга бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 444 тогтоол, 5 тэмдэглэл батлуулж, мөн газрын даргын 170 албан бичгээр хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн зохицуулалтын асуудлыг шийдвэрлүүлсэн. Үүнд:

санг баяжуулах		- Эд хөрөнгийн зохицуулалт хийж, шийдвэр гарсан тухай бүр бүртгэл мэдээллийн өөрчлөлт, баяжилт хийсэн байх.	балансын үнэ бүхий хөрөнгийн шилжилт, хөдөлгөөний зохицуулалт хийж, ТӨБЗГ-ын 794 тогтоол шийдвэрийг гаргасан. Орон нутгаас төрийн өмчид 10.0 тэрбум төгрөгийн эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг шийдвэрлэсэн.	боловсруулж, шийдвэрлүүл-сэн байна. - Төрийн өмчит 1000, орон нутгийн өмчит 5000 гаруй хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөний бүртгэлийг хянаж, мэдээллийг баяжуулсан байна.		– 466 байгууллагын 32993 нэрийн 221.56 тэрбум төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хасах; – 267 байгууллагын 2269 нэрийн 125.07 тэрбум төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх; – 322 байгууллагын 1408 нэрийн 1,490.76 тэрбум төгрөгийн хөрөнгө бүртгэх; – 6 байгууллагын 45 нэрийн 1.10 тэрбум төгрөгийн хөрөнгө шинээр олж авах; – 58 байгууллагын 223 нэрийн 14.40 тэрбум төгрөгийн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах; – 151 байгууллагын 62.34 тэрбум төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 16674 нэрийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг 26.44 тэрбум төгрөгөөр шинэчлэн тогтоох. (100 хувь)
Арга хэмжээ 9.2. (30) Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчийн “Захиргааны статистикийн мэдээлэл”-ийг боловсруулж, дүн шинжилгээ хийж, тайлагнах	12.3 сая	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчийн захиргааны статистикийн мэдээллийг хүлээн авч, нэгтгэн тайлагнасан байх.	Төрийн өмчит 1052, орон нутгийн өмчит 4800 хуулийн этгээдийн захиргааны статистикийн мэдээллийг жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор ҮСХ-нд хүргүүлж байна.	Төрийн өмчит 1052, орон нутгийн өмчит 5000 хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчийн захиргааны статистикийн мэдээллийг нэгтгэн боловсруулж, холбогдох танилцуулга, дүгнэлтийн хамт ҮСХ-нд хуулийн хугацаанд хүргүүлнэ.	I-II улирал, ТӨБАХ	Улсын хэмжээний төрийн өмчит 1057, орон нутгийн өмчит 4647, нийт 5704 хуулийн этгээдийн захиргааны статистикийн мэдээллийг нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн байгууллагаас хүлээн авч нэгтгэн Үндэсний статистикийн хороонд цахимаар хүргүүлсэн. (100 хувь)

Арга хэмжээ 9.3. (31) Төрийн өмчит хуулийн этгээдийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, өмч, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг хүлээн авч хянан нэгтгэх	12.3 сая	- Төрийн өмчит 1052 хуулийн этгээдийн санхүүгийн болон хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг хүлээн авч нэгтгэх; - Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлантай тулган баталгаажуулах.	Жил бүр нэгтгэл хийж, тулган баталгаажуулж байгаа.	Төрийн өмчит 1052 хуулийн этгээдийн санхүүгийн болон хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлангийн нэгдсэн дүнг тулган баталгаажуулж гаргасан байна.	I-IV улирал, ТӨБАХ	Нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн байгууллагаас улсын хэмжээний төрийн өмчит 1057, орон нутгийн өмчит 4647, нийт 5704 хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлан, мэдээг авч нэгтгэн Үндэсний Аудитын газарт цахимаар хүргүүлсэн. (100 хувь)
Арга хэмжээ 9.4. (32) Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудлыг шийдвэрлэх, зохицуулах	12.3 сая	- Ерөнхий сайдын томилсон Ажлын хэсгийн ажлыг хариуцан зохион байгуулах; - Дэд ажлын хэсгийг ажиллуулах, холбогдох судалгаа, тооцоо хийх, санал дүгнэлт гаргах, шийдвэрлүүлэх ажлын уялдаа холбоог хангах;	- Засгийн газар хоорондын хэлэлцээр, протоколын нэмэлт, өөрчлөлтийн төслийг батлуулсан; - ОХУ-ын өмчлөөс Монгол Улсын өмчлөлд орон сууцны 8 байрыг шилжүүлэн хүлээн авах ажиллагааг зохион байгуулсан; - Байрыг иргэдэд нь	- Хэрэгжилтийг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулсан байна; - ОХУ-ын талаас ирүүлэх албан бичиг, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлүүлсэн байна; - Ажлын хэсгийн ажлыг үр дүнтэй зохион байгуулж, холбогдох шийдвэрийг гаргуулсан	I-IV улирал, ТӨБАХ	Ерөнхий сайдын 2016 оны 91 дүгээр захирамжаар байгуулагдсан “Монгол Улс дахь ОХУ-ын өмчийн маргаантай асуудлыг шийдвэрлүүлэх” ажлын хэсгийн хүрээнд ОХУ-тай хийх хамтарсан цахим хурлыг зохион байгуулж, холбогдох мэдээ, мэдээлэл, санал солилцон цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцсэн. Монголын талын Ажлын хэсгийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: – Монгол-Оросын хамтарсан 3 дугаар сургууль дээр ажиллаж, тус сургуулийн хөрөнгө, газар эзэмшилтэй холбоотой болон бусад баримт материалыг бэлтгэн, танилцуулга бэлтгэсэн. – Монголын талын Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, хамтарсан Ажлын хэсгийн хуралд бэлтгэсэн. – Лениний нэрэмжит клубын барилга, газар эзэмшлийн талаар танилцуулга, тайлан бэлтгэж Засгийн газрын 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хэлэлцсэн асуудалтай холбоотой Засгийн газрын

		- Холбогдох байгууллага-тай хамтран ажиллах.	хувьчлах асуудлыг шийдвэрлэсэн.	байна.		хуралдааны 60 дугаар тэмдэглэлийг гаргасан. – 11 дүгээр сарын 23-нд ОХУ-ын талын Ажлын хэсэгтэй хамтарсан хурлыг танхимаар амжилттай зохион байгуулсан. Цаашид хийж хэрэгжүүлэх ажлын дараалал, төлөвлөгөөг хэлэлцэн, хамтарсан протокол гаргасан. – 11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд ОХУ, Монгол Улсын Засгийн газар хоорондын комиссын 23 дугаар хуралдаанд оролцож, шийдвэрийн төсөлд ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн асуудлыг тусгуулан шийдвэрлүүлсэн. (100 хувь)
Стратеги төлөвлөгөөний зорилго 9. Хөрөнгийн удирдлагад хяналт тавьж, бүрэн бүтэн байдлыг хангуулах, зардлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.						
Зорилт 10. **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмчийн удирдлага, санхүүгийн үйл ажиллагаа, төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтын байдалд хяналт шалгалтыг хэрэгжүүлж, зөрчил, доголдлыг арилгуулна.**	**152.5 сая**	- **Хяналт шалгалтын төлөвлөгөө, шаардагдах төсөв батлагдсан байх;** - **Төлөвлөгөө-ний хэрэгжилт, хувиар;** - **Шалгалтад хамрагдах хуулийн этгээдийн тоо;** - **Шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний тоо;** - **Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын**	- **Төлөвлөгөө, зардлын төсөв батлагдсан;** - **Төлөвлөгөө-ний хэрэгжилт – 90 хувь;** - **Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн тоо – 29;** - **Шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний тоо – 140;** - **Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын төсвийн хэмнэлт - 1.7 хувь.**	- **Хяналт шалгалтын төлөвлөгөө, зардлын төсөв батлагдсан байна;** - **Төлөвлөгөө-ний хэрэгжилт – 100 хувь;** - **Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн тоо –35;** - **Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тоо – 126;** - **Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын**	**I-IV улирал,** **ТӨХШХ**	**Хяналт шалгалтын төлөвлөгөө батлагдсан.** **Хяналт шалгалтын зардал батлагдаагүйгээс орон нутагт байршилтай төрийн өмчит хуулийн этгээдэд хийх хяналт шалгалт хэрэгжээгүй. Мөн царх тахлын нөхцөл байдал нөлөөлсөн.** **2021 оны шалгалтад нийт дүнгээр 38 хуулийн этгээд хамрагдсан байна. Үүнээс:** – **Баримтын хяналт шалгалтад – 11 хуулийн этгээд;** – **Системийн хяналт шалгалтад – 11 хуулийн этгээд;** – **Гүйцэтгэлийн хяналт шалгалтад – 10 хуулийн этгээд;** – **Төлөвлөгөөт бус хяналт шалгалтад – 6 хуулийн этгээд.** **Хяналт шалгалтын тайлан боловсруулж, дүнг танилцуулсан – 86.4 хувь. 2021 оны 12 дугаар сард дараах 3 хуулийн этгээдэд хяналт шалгалт хэрэгжүүлж байна:** – **“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК;**

		төсвийн хэмнэлт, хувь.		**төсвийн хэмнэлт - 2.5 хувь.**		– **Хавдар судлалын үндэсний төв;** – **Халдварт өвчин судлалын үндэсний төв.** **Шалгалтын мөрөөр 141 арга хэмжээ авсан. Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын төсвийн хэмнэлт - 5.8 хувь.** **(100 хувь)**
Арга хэмжээ 10.1. (33) Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмчийн удирдлага, санхүүгийн үйл ажиллагаанд баримтын хяналт шалгалт хийх	42.4 сая	- Баримтын шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн тоо; - Хяналт шалгалтын тайлан боловсруулж, дүнг танилцуулсан байх, хувиар; - Илрүүлсэн зөрчлийн дүн, төгрөгөөр; - Шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний тоо.	- Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн тоо – 19; - Хяналт шалгалтын тайлан боловсруулж, дүнг танилцуулсан - 100 хувь - Илрүүлсэн зөрчлийн дүн – 21.66 тэрбум төгрөг; - Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний тоо – 104.	- Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн тоо – 25; - Хяналт шалгалтын тайлан боловсруулж, дүнг танилцуулсан байна – 100 хувь; - Илрүүлсэн зөрчлийн дүн, төгрөг; - Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний тоо – 135.	I-IV улирал, ТӨХШХ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2021 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хяналт шалгалт хийх баталсан төлөвлөгөөнд 25 хуулийн этгээдэд баримтын хяналт шалгалт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2021 онд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 11 хуулийн этгээдэд баримтын хяналт шалгалт хэрэгжүүлсэн. Орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх зардлын төсөв батлагдаагүй, мөн Коронавирус (COVID-19)-ын цар тахлын нөхцөл байдлын улмаас дараах 14 хуулийн этгээдэд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн: 1. “Биокомбинат” ТӨҮГ; 2. “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК; 3. “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК; 4. “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК; 5. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК; 6. “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК; 7. “Улаангом дулааны станц” ТӨХК; 8. “Ховдын дулааны станц” ТӨХК; 9. “Хөвсгөл дулааны станц” ТӨХК; 10. “Увс АЗЗА” ТӨХК; 11. “Ховд АЗЗА” ТӨХК; 12. Говь-Алтай АЗЗА” ТӨХК; 13. “Завхан АЗЗА” ТӨХК; 14. “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК; Өмнөх оны хяналт шалгалтын 1 тайлан, энэ оны 8

						нийт 9 баримтын хяналт шалгалтын тайланг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулж, хуралдаанаас гарсан саналыг “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” шийдвэрийн төсөлд тусган албажуулж, холбогдох байгууллагад шалгалтын тайлангийн хамт албан бичгээр хүргүүлсэн. Шалгалтын дүнг мэдээллийн нэгдсэн санд оруулж баяжуулсан. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн хяналт шалгалтын тайланг боловсруулсан бөгөөд дүнг газрын хуралдаанд танилцуулахаар хүлээгдэж байна. Газрын даргын баталсан 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 01/11 дүгээр удирдамжаар “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК –д баримтын хяналт шалгалт хэрэгжүүлж байна. Удирдамжийн дагуу хяналт шалгалт 2022 оны 1 дүгээр сард дуусна. 2021 онд хийсэн баримтын хяналт шалгалтаар (урьдчилсан байдлаар) 5,182.38 сая төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлсэн. Тодруулбал: – “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК - 830.40 сая төгрөг; – “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК - 272.40 сая төгрөг; – “Геологийн судалгааны төв” ТӨҮГ – 57.59 сая төгрөг; – “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ – 788.80 сая төгрөг; – “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК – 1,264.41 сая төгрөг; – “Буянт-Ухаа спортын ордон” ТӨҮГ – хяналт шалгалтыг иж бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байсан; – “Баганууурын дулааны станц” ТӨХК – 1,211.88 сая төгрөг; – “Баганууур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх

						сүлжээ” ТӨХК – 756.90 сая төгрөг; – “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК /ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулахаар хүлээгдэж байна/; – “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК /ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулахаар хүлээгдэж байна/; – “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК. Хяналт шалгалтын дүнгээр гарсан тогтоол шийдвэрт авч хэрэгжүүлэх, хугацаатай 89 арга хэмжээ тусгагдсан. (100 хувь)
Арга хэмжээ 10.2. (34) Төрийн өмчит төсөвт хуулийн этгээдийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтад системийн хяналт шалгалт хийх	33.9 сая	- Шалгалтад хамрагдах хуулийн этгээдийн тоо; - Хяналт шалгалтын тайлан боловсруулж, дүнг танилцуулсан байна, хувиар; - Илрүүлсэн зөрчлийн дүн, төгрөгөөр; - Шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний тоо.	- Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн тоо – 7; - Хяналт шалгалтын тайлан боловсруулж, дүнг танилцуулсан байна – 70 хувь; - Илрүүлсэн зөрчлийн дүн – 370.4 сая төгрөг; - Шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний тоо – 36.	- Шалгалтад хамрагдах төрийн өмчит төсөвт хуулийн этгээдийн тоо-10; - Хяналт шалгалтын тайлан боловсруулж, дүнг танилцуулсан байна – 100 хувь; - Илрүүлсэн зөрчлийн дүн, төгрөгөөр; - Шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний тоо – 40.	I-IV улирал, ТӨХШХ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2021 онд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төрийн өмчит 11 хуулийн этгээдэд системийн хяналт шалгалт хэрэгжүүлсэн. 2021 оны 7 системийн хяналт шалгалтын тайланг газрын хуралдаанд танилцуулж, хуралдаанаас гарсан саналыг “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” шийдвэрийн төсөлд тусган албажуулж, холбогдох байгууллагад тайлангийн хамт албан бичгээр хүргүүлсэн. Шалгалтын дүнг мэдээллийн нэгдсэн санд оруулж баяжуулсан. Дорнод аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэгт хийсэн хяналт шалгалтын тайланг боловсруулсан бөгөөд дүнг газрын хуралдаанд танилцуулахаар хүлээгдэж байна. Хавдар судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төвд хийсэн хяналт шалгалт 2021 оны 12 дугаар сарын 30-нд дуусах тул 2022 оны 1 сард тайланг боловсруулж, дүнг танилцуулна. 2021 онд хийсэн системийн хяналт шалгалт дүнгээр (урьдчилсан байдлаар) 939.33 сая төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлсэн байна. Тодруулбал:

						1. Монгол Улсын Консерватори - 234.00 мян.төгрөг; 2. Барилгын политехник коллеж – 25.90 сая төгрөг; 3. Үйлдвэрлэл урлалын политехник коллеж – 110.00 сая төгрөг; 4. Монгол Солонгосын политехник коллеж – 1.20 сая төгрөг; 5. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв – 3.60 сая төгрөг; 6. Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль – 33.03 сая төгрөг; 7. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв – 765.36 сая төгрөг. Хяналт шалгалтын дүнгээр гарсан тогтоол шийдвэрт авч хэрэгжүүлэх, хугацаатай 45 арга хэмжээ тусгагдсан байна. (100 хувь)
Арга хэмжээ 10.3. (35) Төрийн өмчийн өмчийн удирдлага, санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хэрэгжүүлэх	16.9 сая	- Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн тоо; - Ажлын хэсэг байгуулсан байх, тухай бүр; - Хяналт шалгалтын үр дүнг тайлагнасан байна, хувиар.	- Батлагдсан удирдамжийн дагуу хийсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтын тоо - 7 - Хяналт шалгалтын тайлан, санал, дүгнэлтийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан.	Шийдвэр, удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хэрэгжиж, тайлан боловсруулж, санал, дүгнэлтийг тайлагнасан байна.	I-IV улирал, ТӨХШХ	2021 онд дээд газрын шийдвэр, удирдажийн дагуу нийт 6 хуулийн этгээдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна. Үүнд: – “Эрдэнэс Тавантолгой” ХК; – “Тавантолгой түлш” ХХК; – “Эрдэнэс Монгол” ХХК; – “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК; – “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК; – “Төрийн орон сууцны корпораци” ХХК. 1.“Эрдэнэс Тавантолгой” ХХК-д шалгалтаар 18 төрлийн 290.64 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлж, шалгалтын тайлан, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан Ажлын хэсгийн тайланд нэгтгүүлэхээр Сангийн яаманд хүргүүлсэн байна. 2.Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 16, А/32 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж, “Эрдэнэс

						Монгол” ХХК, “Тавантолгой түлш” ХК, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК, “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-иудын 2019, 2020 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаа, охин компанийн үйл ажиллагааны өнөөгийн байдалд шалгалт хийсэн. Дээрх компаниудад шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал: – “Эрдэнэс Монгол” ХХК – 9.1 их наяд төгрөгийн хувьцааны бүртгэлтэй холбоотой, 128.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэх ажиллагаатай холбоотой; – “Тавантолгой түлш” ХК - 1.0 сая төгрөгийн 1 эзэмшил газрын зөрчил; – “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК - 53.1 сая төгрөгийн зөрчил; – “Эрдэнэс Силвер” ХХК-д зөрчил дутагдал илрээгүй. Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Ц.Нямдоржоос ирүүлсэн албан үүргийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2021 оны А/74 дүгээр тушаалаар “Төрийн орон сууцны корпораци” ХХК-д мэдээллийн мөрөөр төлөвлөгөөт бус хяналт шалгалт гүйцэтгэх ажлын хэсэгт ажиллаж, тайланг ажлын хэсэгт нэгтгүүлсэн. (100 хувь)
Арга хэмжээ 10.4. (36) Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдалд гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж, үр дүнг тооцох	25.4 сая	- Гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамрагдсан төрийн өмчит хуулийн этгээдийн тоо; - Хяналт шалгалтын тайлан боловсруулж, дүнг танилцуулсан	- Гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамрагдах төрийн өмчит хуулийн этгээдийн тоо - 10; - Хяналт шалгалтын тайлан боловсруулж, дүнг	- Гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамрагдах төрийн өмчит хуулийн этгээдийн тоо - 10; - Хяналт шалгалтын тайлан боловсруулж, дүнг	I-IV улирал, ТӨХШХ	2020 онд гүйцэтгэсэн хяналт шалгалтын дүнгээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 86 компани, үйлдвэрийн газарт дотоод хяналтыг сайжруулж, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, санхүүгийн сахилга батыг хэвшүүлж, ажлын хариуцлага дээшлүүлэх тухай албан даалгаврыг хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна. ТӨБЗГ-ын албан даалгаврын хэрэгжилтийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг 2021 оны эхний хагас жилийн байдлаар төрийн өмчит болон төрийн

		байна, хувиар; - Хяналт шалгалтын үр дүнг нэгтгэж тайлагнасан байх.	танилцуулсан байна - 100 хувь; - Хяналт шалгалтын үр дүнг нэгтгэж, ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуула-хаар бэлтгэж байна.	танилцуулсан байна – 100 хувь; - Хяналт шалгалтын үр дүнг нэгтгэж, ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулж, албажуулсан байна.		өмчийн оролцоотой хуулийн этгээдээс ирүүлсэн. Албан даалгаврын хэрэгжилтийн талаар 14 хуулийн этгээдийг сонгон тухайн хуулийн этгээдийн удирдлагууд болон санхүүгийн холбогдох албан хаагчидтай 2021 оны 7 дугаар сарын 01, 02-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулж, албан даалгаврын явцтай танилцан, мэргэжил, арга зүйгээр хангасан. Үүнд: 1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ; 2. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК; 3. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК; 4. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК; 5. “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК; 6. “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ; 7. “Хөвсгөлийн дулааны станц” ТӨХК; 8. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК; 9. “Улаангом дулааны станц” ТӨХК; 10. “Техник спортын төв” ТӨҮГ; 11. “Диспетчерийн үндэсний төв” ХХК; 12. “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК; 13. “Талын зам” ТӨХК; 14. “Амгалан дулааны станц” ТӨХК. 2021 оны 3 дугаар улиралд багтаан тогтоол шийдвэрийн биелэлт ирүүлэх нийт 10 хуулийн этгээдэд гүйцэтгэлийн шалгалт хийсэн. Үүнээс биелэлтийг хугацаандаа ирүүлээгүй 6 хуулийн этгээдэд албан шаардлага хүргүүлэв. Үүнд: 1. Монгол-Солонгосын политехник коллеж; 2. Үйлдвэрлэл урлалын политехник коллеж; 3. “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК; 4. Барилгын политехник коллеж; 5. “Геологийн төв лаборатори” ТӨҮГ; 6. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ. Гүйцэтгэлийн шалгалтын үр дүн: “Геологийн төв лаборатори” ТӨҮГ нь ерөнхий нягтлан бодогчийг

						хариуцсан ажилдаа зөрчил гаргаж, үүрэг даалгавар хангалтгүй биелүүлсэн үндэслэлээр ажлаас чөлөөлсөн байна. Монгол Улсын Консерваторын хашаанд байрлах хариуцах эзэнгүй сурталчилгааны самбарыг буулгаж, талбайг чөлөөлсөн. Үйлдвэрлэл урлалын политехник коллеж нь хөдөлмөрийн гэрээгээ хангалтгүй биелүүлж, үүрэгт ажилдаа хайнга хандсан үндсэн хөрөнгийн нярав, эргэлтийн хөрөнгийн няравтаа сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байна. 2020 онд хэрэгжүүлсэн хяналт шалгалтын дүнд гаргасан ТӨБЗГ-ын “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолын биелэлтийг хангуулах зорилгоор төрийн өмчит 10 хуулийн этгээдэд гүйцэтгэлийн шалгалтыг хэрэгжүүлж, үнэлгээгээр 9 байгууллага “Тодорхой үр дүнд хүрсэн”, 1 байгууллага “Эрчимжүүлэх шаардлагатай” байгаа тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, 2021 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 03 дугаар тэмдэглэл гаргасан. (100 хувь)
Арга хэмжээ 10.5. (37) Өмчийн харилцааны асуудлаар төрийн өмчит хуулийн этгээдийн албан хаагчдыг мэргэжил, арга зүйгээр хангах	8.5 сая	- Танилцуулсан хууль тогтоомж, дүрэм журам эрх зүйн актын тоо; - Мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгт хамрагдсан албан хаагчийн тоо.	- Танилцуулсан хууль тогтоомж, дүрэм журам эрх зүйн актын тоо - 12; - Мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгт хамрагдсан албан хаагчийн тоо - 113.	Хяналт шалгалт хэрэгжүүлж байгаа төрийн өмчит хуулийн этгээдийн албан хаагчдыг мэргэжил, арга зүйгээр хангасан байна.	I-IV улирал, ТӨХШХ	2021 оны хяналт шалгалтад хамрагдсан 19 хуулийн этгээдийн санхүүгийн, худалдан авах ажиллагааны болон хуулийн асуудал хариуцсан болон бусад холбогдох албан хаагч болох нийт 104 албан хаагчдад төрийн өмчийн эд хөрөнгө, түүний хөдлөл, нягтлан бодох бүртгэлийн баримтын бүрдэл, худалдан авалтын үйл ажиллагаа болон тендерийн баримт бичгийн бүрдэл, өмчийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, санал, зөвлөмж өгч, харилцан санал солилцон уулзалт зохион байгуулж ажилласан. (100 хувь)
Арга хэмжээ 10.6. (38) Хяналт шалгалтын	25.4 сая	- Хийсэн хяналт шалгалтын	- Хяналт шалгалтын	- Бүртгэлийн нэгдсэн санд	I-IV улирал,	2021 оны хяналт шалгалтад хамрагдсан төрийн өмчит 19 хуулийн этгээдийн мэдээллийг хяналт

бүртгэлийн нэгдсэн сан бүрдүүлэх		талаарх мэдээллийг нэгдсэн санд бүртгэсэн байна, тухай бүр; - Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн иж бүрдлийн хувь.	бүртгэлийн нэгдсэн сангийн агуулгыг тогтож, хүснэгтийг боловсруулсан. - Хэрэгжүүлсэн хяналт шалгалтын дүнгээр мэдээллийн санг иж бүрэн хөтөлсөн байна – 100 хувь.	бүртгэх хяналт шалгалтын тоо - 35; - Хэрэгжүүлсэн хяналт шалгалтын дүнгээр мэдээллийн санг иж бүрэн хөтөлсөн байна – 100 хувь.	ТӨХШХ	шалгалтын бүртгэл-мэдээллийн нэгдсэн санд бүрэн хөтөлж, баяжилтыг хийж байна. (100 хувь)
Стратеги төлөвлөгөөний зорилго 10. Төрийн өмчийн үр ашгийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, эрсдэлийг бууруулна.						
Зорилт 11. **Төрийн өмчийн үр ашгийн байдалд судалгаа, дүгнэлт хийж, төсвийн сахилга батыг хэвшүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөн зохион байгуулна.**	**16.9 сая**	**- Төрийн өмчийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр боловсруулсан санал, зөвлөмжийн тоо;** **- Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил буурсан байх;**	**- Зөрчлийг арилгах, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр боловсруулсан санал, зөвлөмжийн тоо – 110;** **- Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил 3.0 хувиар буурсан;** **- Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн эд**	**- Боловсруулсан санал, зөвлөмжийн тоо – 175;** **- Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил 5.0 хүртэл хувиар буурсан байна;** **- Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн эд хөрөнгийн ашиглалт сайжирсан байна;** **- Төсвийн сахилга хариуцлага, үр**	**I-IV улирал,** **ТӨХШХ**	**– Төрийн өмчийн үр ашгийн байдалд хийсэн судалгаа, дүн шинжилгээ - 5;** **– Зөрчлийг арилгах, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр боловсруулсан санал, зөвлөмжийн тоо – 146;** **– Санал, зөвлөмж, шийдвэрийг хүргүүлсэн хуулийн этгээдийн тоо – 19;** **– Хяналт шалгалтад хамрагдсан хуулийн этгээдэд өгөх санал, зөвлөмжийг шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний шийдвэрт тусгаж хүргүүлсэн. Ингэснээр шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн эд хөрөнгийн ашиглалт сайжирч, төсвийн сахилга хариуцлага, үр ашгийг дээшилнэ.** **(100 хувь)**

		- Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн хөрөнгийн үр өгөөж дээшилсэн байх.	**хөрөнгийн ашиглалт сайжирсан байна.**	**ашгийг дээшлүүлэх талаар арга хэмжээ авсан байна.**		
Арга хэмжээ 11.1. (39) Төрийн өмчийн үр ашгийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцох	16.9 сая	- Төрийн өмчийн үр ашгийн байдалд хийсэн судалгаа, дүн шинжилгээний тоо; - Зөрчлийг арилгах, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр боловсруулсан санал, зөвлөмжийн тоо; - Санал, зөвлөмж, шийдвэрийг хүргүүлсэн хуулийн этгээдийн тоо; - Гарсан үр дүнг тооцсон байх.	- Төрийн өмчийн үр ашгийн байдалд хийсэн судалгаа, дүн шинжилгээ - 3; - Холбогдох санал, зөвлөмжийн тоо – 110; - Санал, зөвлөмж, шийдвэрийг хүргүүлсэн хуулийн этгээдийн тоо - 30.	- Төрийн өмчийн үр ашгийн байдалд хийх судалгаа, дүн шинжилгээ - 3; - Зөрчлийг арилгах, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр боловсруулсан санал, зөвлөмжийн тоо – 175; - Санал, зөвлөмж, шийдвэрийг хүргүүлсэн хуулийн этгээдийн тоо – 35; - Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн эд хөрөнгийн ашиглалт	I-IV улирал, ТӨХШХ	2020 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнгээр 2021 онд байгууллагын дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэх талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн А-1/66 дугаартай албан бичгээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 86 хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, захирал нарт 14 заалт бүхий албан даалгавар хүргүүлсэн. Албан даалгаврын хэрэгжилтийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг 2021 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлсэн. Албан даалгаврын хэрэгжилтийн талаар 14 хуулийн этгээдийг сонгож, тухайн хуулийн этгээдийн удирдлагуудтай цахимаар уулзалт зохион байгуулан санал солилцож, мэргэжил, арга зүйгээр хангасан. 2021 оны жилийн жилийн эцсийн хэрэгжилтийг 2022 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн дотор төрийн өмчит компани, үйлдвэрийн газраас ТӨБЗГ-т ирүүлэх тул 2022 оны 1 дүгээр улиралд багтаан нэгтгэж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2020 оны 12 дугаар

				сайжирсан байна.		сарын 25-ны өдрийн ХЭГ/3055 дугаартай албан бичгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудад төсвийн сахилга батыг хатуу сахиулах арга хэмжээ аван ажилласан. Энэ ажлын хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 87 хуулийн этгээдийн 2020 он, 2021 оны эхний 2 сарын байдлаар тухайн хуулийн этгээдээс цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор бэлтгэсэн хөрөнгө, бараа материалын судалгааг зориулалт, зарцуулалт, зарцуулсан зардлын байдалд дүн шинжилгээ хийсэн. Судалгаагаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 78 компани, төрийн өмчит үйлдвэрийн газар нийт дүнгээр 6.7 тэрбум төгрөгийн 514 нэр төрлийн бараа материал, ажил үйлчилгээ худалдан авсан байна. Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Монгол Улсын Консерватори, Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуульд 2021 онд хийсэн хяналт шалгалтын тайлан болон илэрсэн нийт 33.26 сая төгрөгийн зөрчлийн эрх зүйн үндэслэл, тэдгээрийг давтан гаргахгүй байх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолын хамт Боловсрол, шинжлэх ухааны сайдад 2021 оны А-1/1921 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Үйлдвэрлэл урлалын политехник коллеж, Монгол-Солонгосын политехник коллеж, Барилгын политехник коллежид 2021 онд хийсэн хяналт шалгалтын тайлан болон илэрсэн нийт 137.10 сая төгрөгийн зөрчлийн эрх зүйн үндэслэл, тэдгээрийг дахин давтан гаргахгүй байх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолын хамт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад 2021 оны А-1/1920

						дугаар албан бичгээр хүргүүлсэн. Зөрчлийг арилгах, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр 146 санал зөвлөмж боловсруулж, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний шийдвэрт тусгаж 19 хуулийн этгээдэд хүргүүлсэн. Ингэснээр шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн эд хөрөнгийн ашиглалт сайжирч, төсвийн сахилга хариуцлага, үр ашгийг дээшилнэ. (100 хувь)
Стратеги төлөвлөгөөний зорилго 11. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэгт шинжилгээ хийж, чиг үүргийн дахин хуваарилалтыг оновчтой болгох, чадавхыг бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.						
Зорилт 12. **Байгууллагын чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ авч, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт бий болох нөхцөлийг бүрдүүлнэ.**	**38.1 сая**	**Хууль, эрх зүйн орчин, чиг үүрэг тодорхой болсон байх; Бүтэц, орон тооны оновчтой хуваарилалт хийгдсэн байх.**	**ТӨБЗГ-ын чадавх сул, 31 орон тоотой ажиллаж, хуулиар олгогдсон зарим чиг үүргийн хийдэл гарч байсан. Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолоор орон тоог 55 болгох шийдвэр гарсан.**	**Хууль, эрх зүйн орчин тодорхой болно; Чиг үүргийн хуваарилалтыг хуульд нийцүүлсэн байна.**	**I-IY улирал, ХЭЗХ, ЗУХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА**	**Байгууллагын стратеги төлөвлөгөө, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох зорилт, арга хэмжээ, байгууллагад хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээг хэрэгжүүлэхэд батлагдсан зохион байгуулалтын нэгж, орон тоо, албан тушаалын тодорхойлолтын хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэн ажилласан. (93.3 хувь)**
Арга хэмжээ 12.1. (40) Төрийн албаны хууль тогтоомжийн дагуу албан тушаалын тодорхойлолтыг батлах, мөрдүүлэх	8.5 сая	- Байгууллагын чиг үүргийн болон ажлын байрны шинжилгээ судалгаанд үндэслэсэн байх; - Ажлын	Ерөнхий сайдын 2020 оны 79 дүгээр захирамжаар байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсон. Зохион	- Албан тушаалын тодорхойлол-тыг хууль, журмын дагуу боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн хянаж,	I улирал, ЗУХ, Бусад хэлтэс, алба	ТӨБЗГ-ын даргын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/72 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зохион байгуулалтын нэгжийн орон тоо, албан тушаалын жагсаалт”-ын дагуу төрийн захиргааны 25, төрийн үйлчилгээний 9, нийт 34 албан тушаалд Засгийн газраас тогтоосон 55 орон тоотойгоор ажиллаж байна.

		ачааллыг тэнцвэртэй хуваарилсан байх; - Албан тушаалын тодорхойлол-тыг мөрдүүлсэн байх.	байгуулалтын бүтцийн нэгжийн орон тооны хязгаар, албан тушаалын жагсаалтыг ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/72 дугаар тушаалаар баталсан.	зөвшөөрснөөр баталсан байна; - Албан тушаалын тодорхойлол-тыг мөрдүүлэх арга хэмжээг авсан байна.		Байгууллагын чиг үүргийн болон ажлын байрны шинжилгээ хийсний үр дүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төрийн захиргааны 20 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн хянуулж, батлах зөвшөөрөл авсан. Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 06 дугаар тогтоолоор 5 албан тушаалын тодорхойлолтыг шинээр, 07 дугаар тогтоолоор 8 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн, 08 дугаар тогтоолоор 7 албан тушаалын тодорхойлолтыг өөрчлөн тус тус батлах зөвшөөрөл олгосны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн А/07, А/08, А/09 дүгээр тушаалаар уг албан тушаалын тодорхойлолтуудыг батлан мөрдүүлэв. Мөн Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 102 дугаар тогтоолоор зөвшөөрсний дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан төрийн захиргааны 3 албан тушаалын тодорхойлолт хэвээр, 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/88 дугаар тушаалаар батлагдсан төрийн үйлчилгээний албан тушаалын 9 тодорхойлолт тус тус мөрдөгдөж байна. Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамжаар томилогдсон газрын дарга, дэд даргын албан тушаалын тодорхойлолт ЗГХЭГ-аас батлагдан мөрдөгдөж байгаа болно. Албан хаагчдад албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-д заасны дагуу албан ёсоор танилцуулж, мөрдүүлэх арга хэмжээ авав. (100 хувь)

Арга хэмжээ 12.2. (41) ТӨБЗГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон тоо, албан тушаалын жагсаалтын өөрчлөлтийн дагуу боловсон хүчнийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	12.7 сая	- Сул орон тоог хууль тогтоомжийн дагуу бүрдүүлсэн байх; - Албан хаагчдын хөдлөл, өөрчлөлтийн мэдээ, тайланг гаргаж, нээлттэй мэдээлсэн байх.	2020 онд 3 ахлах түшмэлийн сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулсан.	- Хуульд тогтоомжийн дагуу албан тушаалын тусгай шаардлага, шалгуур хангасан албан хаагчийг томилон ажиллуулсан байна.	I улирал, ЗУХ	Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэг өөрчлөгдөн улмаар Ерөнхий сайдын 2020 оны 79 дүгээр захирамжаар тус байгууллагын бүтэц шинэчлэгдэн батлагдсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А-1/1529 дугаар “Сул орон тооны захиалга хүргүүлэх тухай” албан бичгээр Төрийн албаны зөвлөлд 9 сул орон тооны захиалгыг хүргүүлсэн. Тус захиалгын дагуу дэс түшмэлийн ангилалд хамаарах 9 албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөл зохион байгуулан сонгон шалгаруулалтад тэнцсэн 9 иргэнийг Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн “Нэр дэвшүүлж, санал болгох тухай” 358 дугаар тогтоолыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлсэн. Үүний дагуу Хүний нөөцийн мэргэжилтэн, Хурлын зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн, Удирдлага, төлөөллийн албаны мэргэжилтний 4 сул орон тоог нөхөн 4 иргэнийг төрийн жинхэнэ албанд тушаалд томилон Төрийн захиргааны албан хаагчийн Тангараг өргөх ёслолын үйл ажиллагааг 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан. Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргад 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А-1/1846 албан бичгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Дэд даргын, 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А-1/1992 дугаар албан бичгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан тушаалын сонгон шалгаруулалтыг явуулах захиалгыг Төрийн албаны зөвлөлд уламжилж өгөх санал хүргүүлэв. (90 хувь)

Арга хэмжээ 12.3. (42) Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ТӨБЗГ-ын чадавхыг бэхжүүлэх, чиг үүргийг оновчтой болгох асуудлыг судлан тусгах	16.9 сая	- Холбогдох судалгаа, шинжилгээ хийсэн байх; - Хуулийн төслийн үзэл баримтлалд төрийн өмчийн асуудал хариуцсан байгууллагын чиг үүргийг оновчтой тодорхойлж тусгасан байх.	Уг асуудал Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.	- Хууль, эрх зүйн орчин, чиг үүргийг оновчтой, тодорхой болгох асуудлыг судлан боловсруулж, хуулийн төсөлд тусгасан байна. - Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтот түвшнийг - хангах боломжтой болсон байна.	I-IY улирал, ХЭЗХ, Хуулийн төслийг боловс-руулах ажлын хэсэг	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Төрийн өмчийн хороо нэртэйгээр, статусын хувьд Засгийн газрын тохируулагч агентлаг байх, төрийн болон орон нутгийн өмчийг нэгдмэл удирдлагаар хангах чиг үүрэгтэй байхаар зохицуулалт хийх саналыг ТӨБЗГ-аас хууль санаачлагчид хүргүүлсэн болно. Хууль санаачлагчаас хуулийн төслийн эцсийн найруулга, үзэл баримтлал хамаарч байна. (90 хувь)
Стратеги төлөвлөгөөний зорилго 12. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, агентлагийн үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, тайлагналтын ажлын үр нөлөөг сайжруулна.						
Зорилт 13. **Төрийн захиргааны манлайллыг хангаж, байгууллагын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулна.**	**81.7 сая**	**Хуулиар хүлээсэн үүргийг үр дүнтэй хэрэгжүүлж, хуулийн хүрээнд ажилласан байх.**	**Хүчин төгөлдөр хууль, журам, дүрмийн дагуу байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулж байгаа.**	**Байгууллага, нэгжийн үйл ажиллагааны үр дүнд ахиц гарна.**	**I-IY улирал, ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА**	**ТӨБЗГ нь 55 орон тоотой ажиллаж байгаа бөгөөд үүнээс төрийн албанд 6 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчин нийт албан хаагчдын 63 хувийг эзэлж байгаа бол 0-5 дахь жилдээ төрийн байгууллагад ажиллаж байгаа залуу боловсон хүчин 37 хувийг эзэлж байна байна.** **(97.0 хувь)**
Арга хэмжээ 13.1. (43) Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа	8.5 сая	- Шинэчлэн болон шинээр боловсруулах журам,	Журам, дүрмийг шинэчлэх, хууль тогтоомжид нийцүүлэх	- Төсөлд албан хаагчдын саналыг авч, тусгасан байна;	I-IY улирал, ЗУХ,	ТӨБЗГ-ын даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/48 дугаар тушаалаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ыг, А/47 дугаар тушаалаар “Төрийн өмчийн

Хөдөлмөрийн дотоод журам, Албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын журам бусад шаардлагатай журам, дүрмийг шинэчлэн боловсруулах		дүрмийн жагсаалт гаргах; - Журам, дүрмийн төсөлд албан хаагчдын саналыг тусгах; - Батлуулж, мөрдүүлэх.	шаардлагатай байгаа.	- Төслийг Даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулна; - Батлагдсан журам, дүрмийг мөрдүүлсэн байна.	Ажлын хэсэг	бодлого, зохицуулалтын газрын даргын Зөвлөлийн ажиллах журам”-ыг, А/49 дүгээр тушаалаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”-ийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг тус тус байгуулсан. Ажлын хэсгүүд хуралдсан бөгөөд зарчмын асуудлыг хэлэлцэн тогтсон байна. Журмын төслийг 2019 оноос хэрэгжиж эхэлсэн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2022 оноос хэрэгжиж эхлэх Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2020 онд хэрэгжиж эхэлсэн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, холбогдох бусад хууль тогтоомжийн шинэчлэлтэй уялдуулан боловсруулахаар эрх зүйн болон чиг үүргийн шинжилгээ судалгааг хийж байгаа бөгөөд журмын төслийг боловсруулж байна. (70 хувь)
Арга хэмжээ 13.2. (44) Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, дотоод хяналтын ажлын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх	6.4 сая	- Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийн хувиар; - Зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авсан байх.	Тухайн чиг үүргийг хариуцсан албан тушаал, орон тоо байгууллагын бүтцэд байгаагүй.	- Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна, 90< хувь; - Зөрчил, дутагдлыг арилгах талаар зөвлөмж өгсөн байна.	I улирал, ЗУХ	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоол, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг үндэслэн 2021 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн. <u>1.Хяналт-шинжилгээ, үнэлгээ:</u> Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу дараах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн нэгтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүнд: 1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2021 оны

						эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 78.8 хувь буюу “Хэрэгжих шатанд” үнэлгээтэй байна. Үнэлгээнд нийт 73 шийдвэрийн 122 заалтыг хамруулан үнэлсэн бөгөөд дараах төрлийн хууль тогтоомж, тогтоол шийдвэр байсан: – Монгол Улсын 1 хуулийн 17 заалт; – УИХ-ын 5 тогтоолын 10 заалт; – УИХ-ын Байнгын хорооны 5 тогтоолын 7 заалт; – Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 1 заалт; – Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 зөвлөмжийн 2 заалт; – Засгийн газрын 38 тогтоолын 50 заалт; – Ерөнхий Сайдын 3 захирамжийн 3 заалт; – Засгийн газрын хуралдааны 14 тэмдэглэлийн 23 заалт; – Засгийн газрын 1 албан даалгаврын 9 заалт. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 48.3 хувь нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн менежментийг сайжруулах чиглэлээр, 18.8 хувь нь мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай, 12.2 хувь нь төрийн өмчийн бүртгэл, ашиглалттай холбоотой байсан. 1.2.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ: 2 бодлогын 5 тэргүүлэх зорилтод хамаарах 5 зорилтыг хэрэгжүүлэх 12 арга хэмжээний хэрэгжилтийн явц 60.0 хувь буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” үнэлгээтэй байв. Үнэлгээний дүнг бодлого, арга хэмжээгээр танилцуулбал: – Эдийн засгийн бодлогын 2 зорилтын 3 арга хэмжээ 56.6 хувь;

						– Засаглалын бодлогын 3 зорилтын 9 арга хэмжээ 61.1 хувь. 1.3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны эхний хагас жилийн тогтоолын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Эхний хагас жилд ТӨБЗГ-ын хуралдаан 11 удаа хуралдаж, 318 асуудал хэлэлцэн 300 тогтоол, 16 тэмдэглэл гаргаж, 2 танилцуулга мэдээлэл сонссон байна. Тогтоол, шийдвэрийн 69.6 хувь нь төрийн өмчийн эд хөрөнгийн хөдлөл, өөрчлөлттэй буюу төрийн өмчийн бүртгэл, ашиглалттай холбоотой байв. Программ хангамжийн тусламжтай хэрэгжилтийн мэдээллийг тайлагнаж байгаатай холбоотой тайлагналтын байдал хариуцсан нэгж бүр харилцан адилгүй тайлагнасантай холбоотойгоор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжгүй байдал үүссэн. ТӨБЗГ-ын тогтоолын 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг 2022 оны 01 дүгээр сарын 10-нд хийнэ. <u>2. Дотоод аудит, хяналт:</u> Тайлант хугацаанд дараах чиглэлээр дотоод аудит, хяналтыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэн дүнг удирдлага, албан хаагчдад танилцууллаа. Үүнд: 2.1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд I дүгээр улирлын байдлаар дотоод хяналт хийж гүйцэтгэв. Тайлант хугацаанд 16 албан хаагчид 57 өргөдөл, гомдол ирүүлснээс 39 нь шийдвэрлэгдэж хариу өгсөн, 11 нь хугацаа болоогүй, 6 өргөдөл, гомдол шийдвэрлэгдээгүй, хэрэгжилтийн явц 84.8 хувийн дүнтэй байв. 2.2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирсэн албан бичгийн шийдвэрлэлтэд 2 удаа буюу 2021 оны эхний хагас жил, III улирлын байдлаар

						дотоод хяналт хийв. 2021 оны эхний хагас жилийн байдлаар ТӨБЗГ-т хүлээн авсан хариутай албан бичгийн 92.62 хувьтай, хугацаа хэтэрсэн 92 албан бичиг байсан бол III улирлын байдлаар шийдвэрлэлт 97.87 хувь болж, 21 албан бичгийн шийдвэрлэх хугацаа хэтэрсэн дүнтэй байгаа нь өмнөх улирлаас шийдвэрлэлт өссөн, шийдвэрлэх хугацаа хэтэрсэн албан бичгийн тоо 4.4 дахин буурсан ахиц өөрчлөлт гарсан байна. 2.3.Байгууллагын санхүүгийн гүйцэтгэлд сар бүр төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ болон төсвийн хэлбэлзлийн тайлантай тулган дотоод хяналтыг хийв. (100 хувь)
Арга хэмжээ 13.3. (45) Байгууллагын хэмжээний тайлан, мэдээний нэгдсэн хуваарийг боловсруулж, мөрдүүлэх	4.2 сая	- Хууль, журамд нийцүүлсэн байх; - Хуваарийг батлуулах; - Хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах.	Тухай бүрд нь зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.	- Байгууллагын үйл ажиллагааг тайлагнах зохион байгуулалт, ажлын хуваарилалт сайжирна.	II улирал, ЗУХ	Байгууллагын тайлан, мэдээний нэгдсэн хуваарийн төслийг боловсруулсан. Зарим хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлага байгаа тул батлагдаагүй хүлээгдэж байна. 2021 оны оны хагас, бүтэн жилийн тайлан, мэдээний хуваарийг тухай бүр гарган байгууллагын удирдлага, нэгжийн дарга нар, албан хаагчдад дотоод сүлжээнд байршуулан танилцуулан мэдээлсэн. Холбогдох тайлан, мэдээг хуваарийн дагуу гарган баталгаажуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулан хэрэгжүүлсэн. (100 хувь)
Арга хэмжээ 13.4. (46) Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	4.2 сая	- Хэрэгжилтийн үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байх; - Хэрэгжилтийн хувь; - Тайлангийн ил тод, нээлттэй байдлыг	2020 онд: Нийт 2 бүлэг бодлогын хүрээний 5 тэргүүлэх зорилтод хамаарах 5 зорилтыг хэрэгжүүлэх 12 арга хэмжээний хэрэгжилт 65.0	- Хэлтэс, алба хариуцсан чиг үүрэгтээ хамаарах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж, тайлагнасан байна; - Хуулийн хугацаанд	I-IY улирал, ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хариуцан хэрэгжүүлэх нийт 12 арга хэмжээ тусгагдсаныг хяналтад авч, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь нийт 2 бүлэг бодлогын хүрээний 5 тэргүүлэх зорилтод хамаарах 5 зорилтыг хэрэгжүүлэх 12 арга хэмжээний 11-д нь үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар, 1 арга хэмжээ (4.4.10.1.)-ний хамтран хэрэгжүүлэгч

		хангасан байх.	хувь буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” үнэлгээтэй.	жилдээ 2 удаа тайлагнана; - Хэрэгжилтийн хувь, байгууллагын дүнгээр: 90< хувь байна; - Тайланг нээлттэй мэдээлсэн байна.		байгууллагаар үүрэг хүлээн ажиллаж байна. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2 болон 6.2.3-т заасан аргачлалын дагуу тайлант хугацаанд 2 удаа тайлагнасан. Үүнд: 2020 оны жилийн эцсийн тайлан 65.0 хувь, 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцын тайланг 60.0 хувийн гүйцэтгэлтэй буюу тус тус “Эрчимжүүлэх шаардлагатай” гэсэн дүнтэй дүгнэгдсэн. Тайланг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн цаашид анхаарах, хэрэгжилтийг эрчимжүүлэх асуудлаар 02, 04 тоот тэмдэглэл гарган хэлтэс, алба, албан хаагчид үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулав. Холбогдох журмын дагуу 2 удаагийн тайлан, холбогдох баримт материалыг 2021 оны А-1/195, А-1/1143 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн сан https://new.unelgee.gov.mn/govplan/ цахим системд оруулж, Засгийн газрын хяналт, үнэлгээнд хамруулав. Тайлан, холбогдох шийдвэрийг дотоод сүлжээний https://www.able.mn болон байгууллагын цахим хуудас https://www.pcsp.gov.mn –д байршуулан, ил тод, нээлттэй байдлыг хангасан. 2021 оны жилийн эцсийн тайланг холбогдох журамд заасан хугацаанд буюу дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор тайлагнахаар зохион байгуулалтын арга хэмжээг аван ажиллаж байна. (100 хувь)

Арга хэмжээ 13.5. (47) Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	4.2 сая	- Хэрэгжилтийн үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байх; - Хэрэгжилтийн хувь; - Тайлангийн ил тод, нээлттэй байдлыг хангах.	2020 онд: Хяналтад авсан нийт 95 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 153 заалтын хэрэгжилт 90.3 хувь.	- Хэлтэс, алба хариуцсан чиг үүрэгтээ хамаарах тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж, тайлагнасан байна; - Хуулийн хугацаанд жилдээ 2 удаа тайлагнана; - Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувь байгууллагын дүнгээр: 90< хувь; - Тайланг нээлттэй мэдээлсэн байна.	I-IY улирал, ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг графикт хугацаанд болон Засгийн газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу тайлант хугацаанд 4 удаа гаргаж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. Эдгээрийн дүнг дор танилцуулав. <u>1. 2020 оны жилийн эцсийн тайлан:</u> Нийт 9 төрлийн 95 шийдвэрт хамаарах 153 заалтын хэрэгжилтийг дунджаар 90.26 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан. Цаашид хэрэгжих боломжгүй болсон, хэрэгжих хугацаа дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан зэрэг үндэслэл, шалтгаанаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн системийн хяналтаас хасуулах санал бүхий нийт 5 төрлийн 60 шийдвэрийн 84 заалтын жагсаалтыг хавсарган хүргүүлсэн болно. <u>2. 2021 оны 1 дүгээр улирал:</u> Засгийн газраас 2021 онд шинээр гаргасан 3 төрлийн 12 шийдвэрт хамаарах нийт 17 заалтын хэрэгжилтийг Засгийн газраас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу гаргаж, шуурхай горимоор ЗГХЭГ-т хүргүүлсэн. Эдгээр 17 заалтын хэрэгжилтийн явц 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар дунджаар 54.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна. <u>3. 2021 оны эхний хагас жилийн тайлан:</u> Нийт 9 төрлийн 73 шийдвэрт хамаарах 122 заалтын хэрэгжилтийг дунджаар 78.78 хувийн гүйцэтгэлтэй тайлагнав. <u>4. 2021 оны 3 дугаар улирал:</u> Нийт 3 төрлийн 22 шийдвэрт хамаарах 29 заалтын хэрэгжилтийг Засгийн газраас өгсөн үүрэг, чиглэлийн

						дагуу гаргаж, шуурхай горимоор ЗГХЭГ-т хүргүүлсэн. Эдгээрийн хэрэгжилтийг дунджаар 76.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Тайлан тус бүрийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан https://new.unelgee.gov.mn –д оруулан баталгаажуулж, Засгийн газрын хяналт, үнэлгээнд хамруулсан. Тайланг дотоод сүлжээний https://www.able.mn болон байгууллагын цахим хуудас https://www.pcsp.gov.mn –д байршуулан, ил тод, нээлттэй байдлыг хангасан. 2020 оны жилийн эцсийн болон 2021 оны эхний хагас жилийн тайлангийн дүнг Даргын зөвлөлөөр хэлэлцээд уг зөвлөлийн 2021 оны 01, 05 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар болон ХШҮ-ийн дүгнэлт, зөвлөмжийг байгууллагын дотоод сүлжээнд байршуулах, хэлтэс, албан хаагчдад хүргэх арга хэмжээ авч, хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангаж, явцын хяналт тавин ажиллав. Тайлант хугацаанд 2 удаа ЗГХШҮМСистемийн хяналтаас хасуулах санал, үндэслэлийг ЗГХЭГ-т тавьж, шийдвэрлүүлсэн байна. 2021 оны жилийн эцсийн тайланг нэгтгэн боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэх ажлын бэлтгэл зохион байгуулалтыг хангах арга хэмжээ авч, ажиллаж байна. Тайлангийн нэгтгэлийг холбогдох журмын дагуу дараа оны 1 дүгээр сард хийж, дүн, тайланг ЗГХЭГ-т хүргүүлнэ. (100 хувь)
Арга хэмжээ 13.6. (48) Байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах,	5.3 сая	- Холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, батлуулах;	Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 17 зорилт, 83 арга	- Байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө журам, аргачлалын	I-IҮ улирал, ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ,	Байгууллагын стратеги төлөвлөгөө болон 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг ТӨБЗГ-ын даргын 2021 оны А/16 дугаар тушаалаар байгуулан ажиллуулав. 2021-2024 онд хэрэгжүүлэх “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын стратеги” төлөвлөгөөг Засгийн

хэрэгжилтийг хангах		- Хэрэгжилтийн үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байх; - Хэрэгжилтийн хувь; - Тайлангийн ил тод, нээлттэй байдлыг хангах.	хэмжээний хэрэгжилт дунджаар 86.0 хувь.	дагуу батлагдсан байна; - Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр батлагдсан хугацаа, хуваарийн дагуу тайлагнасан байна; - Хэрэгжилтийн хувь 90< хувь; - Тайланг нээлттэй мэдээлсэн байна.	ТӨБАХ, ТӨХШХ, МТА	газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан холбогдох аргачлал, зааврын дагуу боловсруулан Ерөнхий сайдаар батлуулав. Уг стратеги төлөвлөгөө, холбогдох бодлогын баримт бичиг, хуулиар олгогдсон эрх хэмжээ, чиг үүрэгтэй уялдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж баталсан. Байгууллагын стратеги төлөвлөгөө болон 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг дотоод сүлжээ, байгууллагын цахим хуудсанд байршуулан ил тод нээлттэй байдлыг хангасан. Хэлтэс, алба, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллах талаар нэгжийн удирдлагуудад шуурхай хуралдааны үер чиглэл, үүрэг даалгавар өгсөн. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг шат шатанд хагас, бүтэн жилд тайлагнаж байна. Хэлтэс, алба, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2021 оны эхний хагас жил, жилийн эцсийн тайланг дүгнэх ажлыг холбогдох журмын дагуу хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав. ТӨБЗГ-ын даргын 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/53 дугаар тушаалаар байгууллагын албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг холбогдох журам, аргачлалын дагуу үнэлэх үнэлгээний багийг байгуулан, үнэлгээг хийж байна. (100 хувь)
Арга хэмжээ 13.7. (49) Байгууллага, нэгжийн сарын ажлыг	6.3 сая	- Тайланг нэгтгэж хуулийн хугацаанд	Байгууллагын сар бүрийн ажлын тайланг нэгтгэн	- Зохион байгуулалтын нэгж бүр сарын ажлаа	I-IY улирал, ЗУХ,	Зохион байгуулалтын нэгжүүдээс сар бүрийн ажлын тайланг хүлээн авч нэгтгэн боловсруулж, дараа сарын 05-ны өдрийн дотор Ерөнхий Сайдын Ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тухай бүр

тайлагнах		хүргүүлсэн эсэх; - ЗГХЭГ-ын цахим санд оруулсан эсэх.	боловсруулж, Засгийн газрын цахим санд байршуулсан. Зохион байгуулалтын нэгж бүр сарын ажлаа тайлагнасан.	тайлагнасан байна; - Байгууллагын сарын ажлын тайланг боловсруулж, дараа сарын 05-ны өдрийн дотор Ерөнхий сайдын ажлын алба болон ЗГХЭГазарт хүргүүлсэн байна; - ЗГХЭГ-ын цахим сан www.unelgee.gov.mn –д оруулсан байна.	ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА	хүргүүлэв. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын сарын ажлын нэгдсэн тайланг тайлант хугацаанд 11 удаа гаргасан бөгөөд 12 дугаар сарын тайланг 2022 оны 1 дүгээр сард гаргана. Тайланг хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар: – 2021.02.05-ны өдрийн А-1/245; – 2021.03.04-ний өдрийн А-1/402; – 2021.04.05-ны өдрийн А-1/611; – 2021.05.05-ны өдрийн А-1/737; – 2021.06.03-ны өдрийн А-2/916; – 2021.07.05-ны өдрийн А-1/1184; – 2021.08.05-ны өдрийн А-2/1289; – 2021.09.03-ны өдрийн А-1/1388; – 2021.10.05-ны өдрийн А-1/1587; – 2021.11.03-ны өдрийн А-1/1796; – 2021.12.03-ны өдрийн А-1/1995. Тайлан бүрийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн www.unelgee.gov.mn цахим системийн “Сарын ажлын тайлан”-ийн санд оруулж баталгаажуулан Засгийн газрын хяналт, үнэлгээнд хамруулсан байна. (100 хувь)
Арга хэмжээ 13.8. (50) Байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг боловсруулах	4.2 сая	- Засгийн газрын 2020 оны 206 дугаартай тогтоолоор батлагдсан журмын хүрээнд боловсруулсан эсэх; - Тайлангийн ил тод, нээлттэй байдлыг хангах.	Боловсруулаг-даагүй. Харин Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хагас, бүтэн жил	- Байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг боловсруулж, нээлттэй мэдээлсэн байна.	ІҮ улирал, ЗУХ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний 2021 оны тайланг дараах чиглэлийн хүрээнд 2022.02.01-ний өдрийн дотор боловсруулан тайлагнахаар бэлтгэж байна: 1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд: – Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт; – Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт. 2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ:

			бүрд хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан боловсруулсан.			– Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт; – Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт. 3. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ: – Байгууллагын ил тод байдлын үнэлгээ; – Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ; – Шударга байдлын түвшний үнэлгээ; – Хэрэглэгчийн үнэлгээ. (100.0 хувь)
Арга хэмжээ 13.9. (51) Монгол Улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгах санал боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх	3.2 сая	- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцсэн байх; - Хэлтэс, албаны саналд үндэслэн нэгдсэн санал боловсруулах; - Төсөл, саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн байх.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 2 зорилт, арга хэмжээ тусгагдсан, хэрэгжилт 100 хувь. Холбогдох хуулийн шинэчлэл 2020 онд хүчин төгөлдөр болсон.	Холбогдох хууль тогтоомжийн дагуу хөгжлийн төлөвлөгөөнд тусгах санал боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлнэ.	I улирал, ЗУХ, Бусад хэлтэс, алба	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн Монгол Улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх саналыг боловсруулах ажлыг зохион байгуулж, хэлтэс, албадаас санал авч ажилласан. Саналыг Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан холбогдох зорилттой уялдуулан боловсруулсан. ТӨБЗГ-аас боловсруулсан уг саналд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн 4 зорилт, арга хэмжээг тусгах санал, салбарын өнөөгийн байдлын танилцуулга, саналын тайлбар, үндэслэл, холбогдох бусад материалыг боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А-1/364 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Саналд тусгасан 4 зорилт, арга хэмжээний 2 нь Монгол Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын

						01-ний өдрийн 56 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан үр дүнтэй байна. Мөн нэг арга хэмжээ нь Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдан батлагдсан байна. (100 хувь)
Арга хэмжээ 13.10. (52) ТӨБЗГ-ын хуралдаан, Даргын Зөвлөлийн хуралдаан, бусад хурлын бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хангаж ажиллах	35.2 сая	- Хэлтэс, албад дэг, журмын дагуу холбогдох материалыг бэлтгэсэн байх; - Хэлэлцэх асуудлыг төлөвлөж, баталсан байх; - Шийдвэрийн ил тод байдлыг хангасан байх; - Хуралдааны шийдвэр, холбогдох материалыг архивын хадгаламжийн нэгж болгон цэгцлэх.	2020 онд ТӨБЗГ-ын хуралдаан нийт 21 удаа зохион байгуулагдаж, 819 асуудлыг хэлэлцэн нийт 780 тогтоол, 26 тэмдэглэл гаргасан. ТӨБЗГ-ын даргын зөвлөлийн хуралдаан 4 удаа хуралдаж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хэлэлцэж, тэмдэглэл гаргасан. Удирдлагын шуурхай хурал 17 удаа зохион байгуулагдсан.	- Хуралдааныг төлөвлөгөө, дэг, журмын дагуу тухай бүр зохион байгуулсан байна; - Хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлын тоо, төрлийн судалгаа гарсан байна; - Хуралдааны шийдвэрийн ил тод байдлыг хангасан байна; - Хурлын шийдвэр, холбогдох материалыг архивд шилжүүлсэн байна.	I-IY улирал, ЗУХ, Бусад хэлтэс, алба	<u>1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаан:</u> 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар ТӨБЗГ-ын хуралдааныг нийт 22 удаа зохион байгуулсан. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хуралдааны 85 хувийг цахимаар (орон тооны бус гишүүд цахимаар оролцож, газрын дарга, хэлтсийн дарга нар танхимаар оролцсон), 15 хувийг танхимд зохион байгууллаа. ТӨБЗГ-ын 2020 оны 53 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”-ийн дагуу хуралдааныг зохион байгууллаа. ТӨБЗГ-ын хуралдааны материалыг гишүүдэд хүргүүлж, урьдчилан танилцуулах ажилд Gishuud drive, TUBZ1 drive тусгай интернет хаягуудыг ашиглан цахим хэлбэрээр дамжуулан ажиллаж байсныг хуралдаанаар хэлэлцэх асуудлын материалын нууцлал, аюулгүй байдлыг хангах үүднээс http://share.com.mn серверийг шинээр үүсгэн хуралдааны материалыг байршуулан ажиллаж байна. Тус серверт 2021 оны хуралдааны материал бүхий 663 файлыг байршуулаад байна. Нийт 22 удаагийн хуралдаанаас 628 тогтоол, 35 тэмдэглэл, нийт 663 шийдвэрийг гаргасан байна. ТӨБЗГ-ын хуралдаанаас гарсан шийдвэрийн агуулга: – Хуулийн этгээдийн дүрэм зохион байгуулалтын

						бүтцийн тухай -18; – Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлгөө, тодотгол батлах тухай - 53; – Хуулийн этгээдийн удирдлагыг чөлөөлөх, томилох тухай - 27; – Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн чөлөөлөх, томилох тухай - 19; – Хуулийн этгээдийн удирдлагад хариуцлага тооцох тухай - 5; – Хуулийн этгээдийн бусад асуудлын тухай - 15; – Өмч хувьчлалтай холбоотой - 3; – Хөрөнгийн шилжилт хөдөлгөөний тухай - 506; – Хяналт шалгалтын дүн, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай - 17 шийдвэр. Хуралдаанаас гарсан шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор ТӨБЗГ-ын албан ёсны цахим хуудас http://pcsp.gov.mn -д тухай бүр байршуулж хэвшсэн байна. Газрын хуралдааны зардалд нийт 30,922,400.0 (гучин сая есөн зуун хорин хоёр мянга дөрвөн зуун) төгрөг зарцуулсан байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр он дууссалх хугацаанд 1-2 удаагийн хуралдаан зохион байгуулж, төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын 2022 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлах тухай, мөн төрийн өмчийн бүртгэл ашиглалт, хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн асуудал, төрийн өмчийн хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай зэрэг ойролцоогоор 50-60 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх төлөвлөгөөтэй байна. 2.Даргын Зөвлөлийн хурал: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын Зөвлөл нийт 5 удаа хуралдсан. Мөн ТӨБЗГ-ын даргын 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар уг Зөвлөлийн бүрэлдэхүүнийг

						шинэчлэн томилсон. Даргын Зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, тэмдэглэл гаргасан байна: – Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2020 оны жилийн эцэс, 2021 оны эхний хагас жилийн тайлан, түүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн тухай, 2 удаа; – Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2020 оны жилийн эцэс, 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгийн тухай, 2 удаа; – Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтийн тайлан, үр дүнгийн тухай; – Ардын хувьсгалын 100 жил, Өмч хувьчлалын 30 жил, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үүсэж хөгжсөний 25 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан зарим албан хаагчдыг Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар нэр дэвшүүлэх тухай, салбарын болон байгууллагын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэх тухай; <u>3.Удирдлагын шуурхай хурал:</u> Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны тасралтгүй, хэвийн байдлыг хангах, тулгамдсан асуудлыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, шийдвэрлэх, удирдлагын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах зорилго бүхий удирдлагын шуурхай хурлыг нийт 30 удаа зохион байгуулсан. Хурлаар хэлтэс бүрийн 7, 14 хоногийн тайлан, тулгамдаж буй асуудал, газрын хуралдааны тов, хугацаатай үүрэг даалгавар өгөх, түүний шийдвэрлэлтийн явц, үр дүнг сонсох, яаралтай шийдвэрлэх асуудлаар мэдээлэл, танилцуулга хийх, уялдаа холбоог хангах гэх мэт асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байна.

						Шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын жагсаалтыг гарган байгууллагын дотоод сүлжээний https://www.able.mn цахим системийн “Олон нийтийн” цэсэн дэх “Удирдлагын шуурхай” хэсэгт тухай бүр байршуулж, нийт албан хаагчдад хүргэж, мэдээллийн нэгдмэл байдлыг ханган ажиллаж байна. (100.0 хувь)
Стратеги төлөвлөгөөний зорилго 13. Авлигын эсрэг үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.						
Зорилт 14. **Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.**	**22.4 сая**	- **Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө-ний хэрэгжилт, хувиар;** - **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, хувь.**	**Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилт – 76.7 хувь.**	- **Төлөвлөгөө-ний хэрэгжилт – 90< хувь;** - **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт – 80< хувь.**	**I-IY улирал,** **ЗУХ, Бусад хэлтэс, алба**	**Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ил тод нээлттэй, хариуцлагатай байх, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох арга хэмжээний хүрээнд төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, төсөв, санхүүгийн тайланг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулан ажиллаж байна.** **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн биелэлт 2020 онд 91.8 хувийн гүйцэтгэлтэй (нэмэлт заалтууд орсон тул дахин үнэлгээ хийгдсэн), 2019 оны дүнтэй харьцуулахад 3.8 хувиар өссөн байна.** **Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлон ТӨБЗГ-ын 50 албан хаагч, төрийн өмчит компанийн 40 хараат бус гишүүн, ТӨБЗГ-ын харъяа төрийн өмчит 19 хуулийн этгээдийн 473 албан хаагч, нийт 563 хүнийг сургалтад хамруулах саналыг Авлыигатай тэмцэх газарт хүргүүлсэн. (100 хувь)**
Арга хэмжээ 14.1. (53) Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэх	6.4 сая	- Төлөвлөгөөг авлигын эсрэг хууль тогтоомжид нийцүүлж, ЗГХЭГ, АТГ-	2020 онд тусгайлсан төлөвлөгөө батлаагүй. Байгууллага, хэлтсийн	- Төлөвлөгөөг хууль тогтоомж, холбогдох байгууллагаас өгсөн чиглэл,	I-IY улирал, ЗУХ, Бусад хэлтэс,	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллав. Төлөвлөгөөнд Авлигатай тэмцэх газрын 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/696 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэл, зааврын дагуу холбогдох 13 арга хэмжээг тусгаж,

		аас өгсөн зөвлөмж, чиглэлийг тусган боловсруулсан байх; - Нэгжүүдийн саналыг тусгах; - Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар.	гүйцэтгэлийн төлөвлөгөө холбогдох зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн.	зөвлөмжийн дагуу боловсруулсан байна; - Нэгжүүд холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн тайлагнана, хагас, бүтэн жилээр; - Төлөвлөгөөний хэрэгжилт – 90< хувь (жилийн эцэс).	алба	хэрэгжилтийг хангасан. Хэрэгжилт 97.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Авлигын эсрэг үйл ажиллагааны хүрээнд АТГ-аас зохион байгуулсан дараах хэлэлцүүлэгт холбогдох албан хаагчдыг оролцуулав. Үүнд, Авлигатай тэмцэх газар болон “Нээлттэй нийгэм форум” ТББ хамтран 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны ил тод байдал” цахим хэлэлцүүлэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын холбогдох 20 албан тушаалтныг оролцуулсан. Цахим хэлэлцүүлгийн үеэр “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын хийсэн холбогдох судалгааны дүн, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж, хэлэлцсэн бөгөөд Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ панель хэлэлцүүлэгт тодорхой санал хэлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан ёсны байр суурийг илэрхийлсэн. Мөн “Авлигатай тэмцэх газрын мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажил, үр дүн” цахим уулзалт, хэлэлцүүлгийг Авлигатай тэмцэх газартай хамтран 06 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Уг цахим уулзалт, хэлэлцүүлэгт АТГ, ТӨБЗГ, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын удирдах ажилтан, холбогдох албан хаагчид оролцож, эдгээр байгууллагуудад АТГ-аас хүргүүлсэн мөрдөгчийн мэдэгдэл (4)-ийн хүрээнд харилцан мэдээлэл солилцож, цаашид анхаарах асуудлын талаар ярилцав. (100.0 хувь)
Арга хэмжээ 14.2. (54) Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг	3.2 сая	- Холбогдох зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2020 оны	- Холбогдох зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг	I-IY улирал, ЗУХ,	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтийн тайланг боловсруулж, Авлигатай

зохион байгуулах, тайлагнах		ажлыг нэгжүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөн-дөө тусган хэрэгжүүлсэн байх; - Хэрэгжилтийг жилийн эцэст тайлагнах, хэрэгжилтийн хувиар.	хэрэгжилт – 76.7 хувь.	нэгжүүд тайлагнасан байна; - Байгууллагын нэгдсэн тайланг боловсруулж, үр дүнг тооцон АТГ-т хуулийн хугацаанд хүргүүлсэн байна; - Хэрэгжилт, байгууллагын дүнгээр – 80< хувь.	Бусад хэлтэс, алба	тэмцэх газарт хуулийн хугацаанд буюу 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/91 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 76.7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй тайлагнасан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг цахим санд тайлагнах ажлыг АТГ-аас зохион байгуулж, энэ хүрээнд цахим санд мэдээлэл оруулах, биелэлтийг үнэн зөв, бодитой гаргах арга зүйн зөвлөмж, мэдээллээр хангах санал солилцох сургалт хэлэлцүүлгийг 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан. Уг сургалт, хэлэлцүүлгийн үеэр АТГ-аас өгсөн чиглэлийн дагуу үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг АТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан http://khutulbur.iaac.mn системд 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор оруулах арга хэмжээ авч ажиллав. Энэ үеэр дахин үнэлгээ хийхэд (АТГ-аас нэмэлт заалтуудыг хамааруулан оруулсан тул дахин үнэлсэн) хөтөлбөрийн хэрэгжилт 2020 оны дүнгээр 91.8 хувийн гүйцэтгэлийн дүнтэй тодотгол хийгдсэн байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох арга хэмжээг байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авсан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.2.4-2 дахь хэсэгт тусгагдсан хэд хэдэн байгууллагын оролцоотой хэрэгжих “Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх” гэсэн арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаатай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ирүүлсэн чиглэл, хүсэлтийн дагуу байгууллага дундын ажлын хэсэгт ажиллах 3 албан хаагчийн нэрийг 2021 оны А-2/890 дугаартай албан бичгээр Мэргэжлийн

						хяналтын ерөнхий газарт хүргүүлсэн. (100 хувь)
Арга хэмжээ 14.3. (55) Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг байгууллагын албан хаагчид, харьяа байгууллагын холбогдох албан тушаалтны дунд зохион байгуулах, зөвлөгөө, арга зүй, мэдээллээр хангах	6.4 сая	- Сургалтын хэрэгцээг тодорхойлох; - Сургалт, сурталчилгааны ажилд хамруулсан албан хаагчдын тоо; - Зөвлөгөө, мэдээлэл, арга зүйн дэмжлэгт хамрагдсан албан хаагчдын тоо.	2020 онд: - Сургалт, сурталчилгааны ажилд хамруулсан албан хаагчдын тоо - 0; - Зөвлөгөө, мэдээлэл, арга зүйн дэмжлэгт хамрагдсан албан хаагчдын тоо - 250.	- Сургалт, сурталчилгааны ажилд 150< албан хаагчдыг хамруулсан байна; - Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллана; - Зөвлөгөө, мэдээлэл, арга зүйн дэмжлэгээр 110< албан хаагчдыг хангасан байна.	I-IY улирал, ЗУХ	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах хэрэгцээ шаардлагыг судлан Авлигатай тэмцэх газрын УССГХ-т сургалт авах тухай санал өгч, сургалтын төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээ авсан. Саналыг 2 дугаар сард өгч, АТГ-ын хүсэлтээр 5, 11 сард шинэчлэн тодотгосон боловч сургалт, соён гэгээрүүлэх ажил цар тахлын үеийн нөхцөл байдал, бусад хүчин зүйлээс шалтгаалан бүрэн хангалттай хэрэгжээгүй. ТӨБЗГ-ын 2 албан хаагчийг АТГ-ын Олон нийтийн төвд зохион байгуулсан давтан сургалтад хамруулаад байна (ЗУХ-ийн дарга, хуулийн мэргэжилтэн). Мөн АТГ-аас 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан “Авлигын эсрэг үндэсний чуулган”-д ЗУХ, ТӨУЗХ-ийн дарга нар оролцсон. Мэдүүлэг гаргагч албан хаагчид болон харьяа байгууллагын ЭБАТ-уудыг тухай бүр зөвлөгөө, арга зүйгээр хангаж ажилласан. Тайлант жилд авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлан таниулах чиглэлээр ТӨБЗГ-ын мэдүүлэг гаргагч албан хаагчид, харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн захирал, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ, нийт 206 албан хаагчдад мэдээлэл, зөвлөгөө, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан байна. 2021 оны 2 дугаар сарын 08-ны өдөр, 6 дугаар сарын 07-ны өдөр АТГ-ын Хяналт-шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс зохион байгуулсан сургалтад харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн шинээр томилогдсон 14 ЭБАТ-ыг оролцуулах арга хэмжээ авсан. Авлигатай тэмцэх газар болон “Нээлттэй нийгэм форум” ТББ хамтран 2021 оны 4 дүгээр сарын 28-ны

						өдөр зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны ил тод байдал” цахим хэлэлцүүлэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын холбогдох 20 албан тушаалтныг оролцуулсан. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын удирдах ажилтнуудыг оролцуулсан нийтлэг гарч байгаа хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг арилгах, цаашид давтан гаргуулахгүй байх асуудлаар 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр цахим хэлэлцүүлэг хийж, мэдээлэл, санал солилцсон. (100 хувь)
Арга хэмжээ 14.4. (56) Авлигын эсрэг хууль тогтоомжид заасан мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнах	6.4 сая	- Мэдүүлэг гаргагч албан хаагч, харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтныг удирдлага, зохион байгуулалт, мэдээлэл, арга зүйгээр хангах; - Мэдүүлгийн бүрдүүлэлтийн нэгдсэн тайланг боловсруулж, АТГ-т хуулийн хугацаанд хүргүүлэх; - Холбогдох	2020 онд ТӨБЗГ болон харьяа 49 хуулийн этгээдийн 2019 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийг хуулийн хугацаанд тайлагнасан. Уг тайланд 694 мэдүүлэг гаргагч албан тушаалтны ХАСХОМ, хөрөнгө орлогын 48 их хэмжээний өөрчлөлт, 230 ХАСУМ, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай 2781	- 2020 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийг 03 дугаар сарын 1-ний дотор нэгтгэн АТГ-т хуулийн дагуу тайлагнана; - 2021 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулсан байна. - Явцын мэдээг байгууллага, нэгжийн тайлан мэдээнд тусгасан	I-IY улирал, ЗУХ	1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий 41 албан тушаалтан (ЭБАТ)-ы мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажил, 2020 оны тайлан мэдээ, гаргах үйл ажиллагаанд хяналт тавин холбогдох заавар, зөвлөгөө өгч, удирдлага, чиглэлээр ханган ажиллав. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 41 хуулийн этгээдэд 2021 оны 2 дугаар сарын 15-ны дотор нийт 620 албан хаагч 2020 оны ХАСХОМ-ээ шинэчлэн гаргаж, бүртгүүлсэн байна. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2020 оны тайланг хүлээн авч, тулган баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэн нэгдсэн дүнг гаргаж, тайланг хуулийн хугацаанд буюу 2021 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А-1/363 дугаартай албан бичгээр АТГ-д хүргүүлсэн. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2020 оны тайланд нэгтгэгдсэн дүн мэдээг тоймлон танилцуулбал: – Мэдүүлгийн бүрдүүлэлтэд хамрагдсан байгууллага – 50 (ТӨБЗГ, ТӨХЭ);

		мэдээг байгууллагын тайлан мэдээнд тусгах.	мэдэгдэл, тайлбарын бүрдүүлэлтийг тусган тайлагнасан.	байна; - Албан тушаалтныг мэдээлэл, арга зүйгээр хангасан байна.		– 2020 оны ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлсэн хүний тоо – 692 (Үүнээс: 620 нь 41 ТӨХЭтгээдэд, 50 хуулийн этгээдийн 72 мэдүүлэг гаргагч ТӨБЗГ-т бүртгүүлсэн); – Тухайн жилд их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлсэн мэдүүлгийн тоо – 18; – Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай мэдэгдлийн тоо – 2233; – Ашиг сонирхлын зөрчилтэй тухай мэдэгдлийн тоо – 22; – Албан тушаалд нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хянуулахаар бүртгэн авсан тоо – 194. 2.2021 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг тайлант хугацаанд зохион байгуулж ажиллав. Уг ажлын явцыг ТӨБЗГ-т мэдүүлэг хүлээн авч, бүртгэж байгаа дүн мэдээгээр танилцуулж байна (ТӨБЗГ-т тус байгууллагын албан хаагчдаас гадна харьяа төрийн өмчит 49 компани, үйлдвэрийн газрын удирдлагуудын мэдүүлгийг бүртгэж, хадгалдаг): – ХАСХОМ 2020* (шинээр томилогдсон) – 31; – ХАСХОМ 2020+ (их хэмжээний өөрчлөлт) – 5; – ХАСУМ (хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг) – 51; – АСМ (Албан үүрэг гүйцэтгэх үед ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх тухай асуудлаар гаргасан мэдэгдэл, тайлбар) – 10 . 3.Авлигын эсрэг хууль тогтоомжийн дагуу ХАСУМ, ХАСХОМ-ийг батлагдсан маягтын дагуу хүлээн авах, бүртгэл хөтлөх, түүнийг үндэслэн цахим системд баталгаажуулах, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэсэн. 4.Тайлант хугацаанд нийт 206 мэдүүлэг гаргагч болон ЭБАТ-д мэдээлэл, зөвлөгөө өгч, арга зүйгээр хангасан байна. (100 хувь)

Стратеги төлөвлөгөөний зорилго 14. Төрийн албаны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хүний нөөцийн оновчтой бодлого, стратегийг хэрэгжүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.						
Зорилт 15. **Төрийн албаны хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлж, хүний нөөцийн манлайллыг хангана.**	**21.2 сая**	**Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулсан байх.**	**Хууль тогтоомж, стандартын дагуу ажилласан.**	**Төрийн албаны хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна.** **Төрийн албаны зөвлөлийн зөвлөмж, чиглэлийг хангасан байна.**	**I-IY улирал,** **ЗУХ**	**Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад 20 албан хаагчийг хамруулж, албан хаагчдыг чадавхижуулах, мэргэжлийн ур чадвар, мэдлэг чадварыг дээшлүүлэх, ёс зүй, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр ажлын байранд болон холбогдох байгууллагаас зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор нийт 328 албан хаагчийг хамруулсан дүнтэй байна.** **Холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг нийт 11 албан хаагчид олгосон байна.** **5 албан хаагчид хууль тогтоомж, дотоод журамд заасны дагуу холбогдох тусламж, 1 албан хаагчид буцалтгүй тусламж олгосон бөгөөд нийт 5,071,552.0 төгрөгийн төсвийг тусламж, дэмжлэгт зарцуулсан байна.** **2021 онд төрийн одон, медалиар 24, салбарын болон байгууллагын шагналаар 22, нийт 44 албан хаагч хөдөлмөрөө үнэлүүлж, шагнагдсан байна.** **Төрийн албаны хууль тогтоомжийн дагуу албан хаагчдын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг дүгнэж, үнэлгээний үндсэн дээр улирлын үр дүнгийн урамшууллыг олгов.** **Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх гэж заасны хүрээнд албан хаагчдаас судалгаа авч, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор Нийслэлийн орон сууц корпорацитай хамтран 11 албан хаагчид орон сууцны дэмжлэг үзүүлсэн.** **(90.0 хувь)**

Арга хэмжээ 15.1. (57) ТӨБЗГ-ын албан хаагчдын сургалтын сургалтын хөтөлбөр, нийгмийн баталгааг хангах 2021-2024 оны хөтөлбөрийг боловсруулах	5.2 сая	- 2017-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт гаргах; - Албан хаагчдын саналыг авч тусгах; - Холбогдох судалгаа, хэрэгцээг судлах; - Хөтөлбөрийн төслийг Даргын зөвлөлөөр хэлэлцүүлэх, батлуулах.	2017-2020 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд жил бүр төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлсэн.	- 2021-2024 оны стратегийг оновчтой тодорхойлж, уг хөтөлбөрийг боловсруулсан байна; - Хөтөлбөрийн төсөлд албан хаагчдын саналыг тусгасан байна; - Төслийг Даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулсан байна.	III улирал, ЗУХ	Албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, удирдах ажилтны манлайлах ур чадварыг хөгжүүлэх, төрийн албан хаагчийг давтан сургах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд албан хаагчдын мэргэшил, ажилласан жил, зэрэг дэв, шагнал, орон сууцны судалгаануудыг гаргасан. (30.0 хувь)
Арга хэмжээ 15.2. (58) ТӨБЗГ-ын албан хаагчдын сургалтын төлөвлөгөө, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах	4.2 сая	- Холбогдох судалгааг гаргаж, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох; - Шаардлагатай төсвийг тооцож, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх; - Төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах; - Хэрэгжилтийн хувь.	2020 онд нийт 24 төрлийн сургалтыг зохион байгуулж, 60 албан хаагчдыг хамруулсан. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээний хүрээнд албан хаагчид 100.4 сая төгрөгийн дэмжлэг олгосон.	- Сургалтын хэрэгцээг тодорхойлсон байна; - Албан хаагчдаас санал авсан байна; - Төлөвлөгөө, шаардагдах төсвийг батлуулж, арга хэмжээг зохион байгуулсан байна; - Хэрэгжилт, үр дүнг тайлагнасан байна.	II-IY улирал, ЗУХ	Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 хэсгийг үндэслэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан ТӨБЗГ-ын даргын А/29 дүгээр тушаалаар батлуулсан. 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 31 төрлийн сургалтыг зохион байгуулахаар сургалтын төлөвлөгөөнд тусгасан бөгөөд 29 төрлийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 348 албан хаагчийг хамруулж, шинэ мэдлэг мэдээлэл олгон мэргэжлийн ур чадварыг ахиулах, чадавхийг дээшлүүлэх арга хэмжээ авсан байна. Үүнд: 1. Мэргэшүүлэх багц сургалт, (нийт 20 албан хаагч) – Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад-1; – Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад – 1; – Ахлах түшмэл мэргэшүүлэх багц сургалтад -2;

						– Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад – 5; – Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад – 5; – Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад – 6. <u>2.Ажлын байран дах сургалт, (давхардсан тоогоор нийт 317 албан хаагч хамрагдсан)</u> – ЗГХЭГ-ын ХШҮДАГ-аас 2021.01.28-ны өдөр зохион байгуулсан Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоолоор батлагдсан журам, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан холбогдох аргачлал, зааврыг таниулах арга зүйн цахим сургалтад - 31; – Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт “Алсын хараа-2050” - 11; – Монгол Улсын хөгжлийн бодлого, зохицуулалт, хэрэгжилт “Алсын хараа-2050” - 11; – Монгол Улсын хөгжлийн бодлого, үнэлгээ “Алсын хараа-2050” - 11; – Компанийн засаглалын сургалт - 16; – Able программын сургалт - 27; – 1234.mn Laravel сургалт - 2; – Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТӨБЭӨОКТ хууль болон дагалдан гарах дүрэм журам - 28; – Төрийн албаны зөвлөл, Архивын ерөнхий газраас хамтран зохион байгуулсан “Төрийн албаны тухай болон Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулиудын хэрэгжилт” сэдэвт арга зүйн сургалтад - 4; – Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Тамга тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын талаарх сургалтад – 8; – Тагнуулын ерөнхий газраас зохион байгуулсан Төрийн болон албаны нууцын тухай хууль

						тогтоомжийн талаарх мэдлэг олгох цахим сургалтад – 10; – ЗГХЭГ-аас 2021.09.29-ний өдөр зохион байгуулсан Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болох хөгжлийн зорилтот 10 хөтөлбөрийг боловсруулахтай холбоотой “Нөхцөл байдлын шинжилгээ хийх арга зүй” цахим сургалтад - 20; – Орхон аймгийн ЗДТГ-аас 2021.10.22-ны өдөр зохион байгуулсан “Төрийн байгууллагын соёл, төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүй” цахим сургалтад - 26; – Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад – 36; – Төрийн албаны зөвлөлөөс Ёс зүйн зөвлөлийн гишүүдэд зориулсан Ёс зүйн сургалтад - 6; – Монголын үг урлаачдын нийгэмлэгийн хүмүүнлэгийн лектор, сэтгэл зүйч Г.Бандицэрэнгийн “Амьдралын үнэ цэнэ” лекцэд – 25; – Мэдээлэл технологийн албанаас зохион байгуулсан Хэрэглээний программ хангамжийн сургалтад – 4; – Мэдээлэл технологийн албанаас зохион байгуулсан Компьютерийн сүлжээ, сүлжээний нууцлал аюулгүй байдлын сургалтад - 4; – Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан хяналт, шинжилгээ, үнэлгээ” сургалтад – 1; – Архивын ерөнхий газраас зохион байгуулсан Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх арга зүй сургалтад - 2; – Авлигын эсрэг сургалтад – 3; – Захиргаа, удирдлагын хэлтсээс зохион байгуулсан Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг тайлагнах, үнэлэх талаарх арга зүйн сургалтад – 31 албан хаагч.

						3.Вакумжуулсан сургалт, (11 албан хаагч) – Төрийн албаны хүний нөөцийн удирдлагад цогц чадамжийн хүрээг нэвтрүүлэх нь” дэд төслийн ажлын хүрээнд “Цогц чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага” сэдэвт вакумжуулсан сургалтад - 11 албан хаагч. Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дах заалтад орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх гэж заасны хүрээнд Нийслэлийн орон сууцны корпорацитай хамтран 11 албан хаагчийг түрээслээд өмчлөх орон сууцны зээлд хамруулах ажлыг зохион байгуулсан. (100.0 хувь)
Арга хэмжээ 15.3. (59) Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулах	3.2 сая	- Албан хаагч бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөг заавар, журмын дагуу оновчтой төлөвлөх, батлуулах; - Хэрэгжилтийн явцад хяналт тавих; - Үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх ажлыг зохион байгуулах; - Үнэлгээний мөрөөр авах арга хэмжээг шийдвэрлэх.	2020 онд албан хаагчдын мэргэшлийн түвшнийг үнэлж, дүгнэсэн.	- Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянан баталгаажуул-сан байна; - Төлөвлөгөөний хэрэгжилтийг журамд заасан хугацаанд тайлагнасан, хянасан байна; - Үнэлгээний баг байгуулж, холбогдох журмын дагуу жилийн гүйцэтгэлийг үнэлж, дүгнэсэн байна; - Үнэлгээний мөрөөр хэрэгжүүлэх	II-IY улирал, ЗУХ, Хэлтэс, албаны дарга нар	Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 1.2, 4.1, 4.2 дахь заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 9 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлалыг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын А/53 дугаар тушаалаар Үнэлгээний баг байгуулан ажиллуулсан. Нэгжийн даргаас өгсөн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн байгууллагын үнэлгээний баг нийт албан хаагчдын 2021 оны эхний хагас жилийн үнэлгээг хэлэлцэн баталгаажуулж, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын дотоод журмыг баримтлан “А буюу Маш сайн”, “В буюу Сайн” үнэлгээ авсан албан хаагчдад урамшуулал олгохоор байгууллагын удирдлагад санал гаргасан. Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан журмын дагуу албан хаагчдад 33,768,214.40 төгрөгийн үр дүнгийн урамшууллыг

				арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн байна.		олгосон. “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах аргачлал”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлал”-ын талаар байгууллагын албан хаагчдад 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдөр сургалт зохион байгуулж нийт 31 албан хаагчийг хамруулав. Албан хаагчдын 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг үнэлэх үнэлгээний багийг ТӨБЗГ-ын даргын 2021 оны А/75 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд нэгжүүдээс тайланг авч журмын дагуу үнэлгээний багаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. (100.0 хувь)
Арга хэмжээ 15.4. (60) Төрийн албан хаагчдад олгох хөдөлмөрийн хөлсний нэмэгдэл, урамшуулал, шагнал, тэтгэмж, тусламжийг хууль тогтоомжийн дагуу судлан шийдвэрлэх	1.2 сая	- Холбогдох судалгааг хийсэн байх; - Цалин хөлсний нэмэгдэл, урамшуулал, шагнал, тэтгэмж, тусламжийн асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн байх; - Хамрагдсан албан хаагчдын тоо.	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 9 албан хаагчид, зэрэг дэвийн нэмэгдлийг 6 албан хаагчдад олгосон.	- Судалгаа хийсэн байна; - Хууль тогтоомжид заасан шалгуур хангасан албан хаагчдыг хамруулсан байна; - Үндэслэл бүхий шийдвэр гарсан байна.	I, IY улирал, ЗУХ	Нийт албан хаагчдын ажилласан жилийн судалгааг гарган Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3, Улсын Их Хурлын 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмын 2.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 2 дахь заалтыг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2021 оны “Зарим албан хаагчдад зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай” Б/17 дугаар тушаалаар Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 1, зэрэг дэвийн нэмэгдлийг 8 албан хаагчид тус тус олгосон байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг үндэслэн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 2 албан хаагчид олгосон. Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалтыг үндэслэн 5 албан хаагчийн ар гэрт гачигдал гарсантай холбогдуулан тусламж, 1 албан

						хаагчид 2 сарын цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй тусламж, нийт 5,071,552.0 төгрөгийн тусламж, дэмжлэгийг тус тус олгосон. 2021 оны шагналын судалгааг гарган төрийн дээд шагнал болон салбарын шагналд албан хаагчдаа тодорхойлж, төрийн одон медалиар 24, салбарын болон байгууллагын шагналаар 22, нийт 44 албан хаагч хөдөлмөрөө үнэлүүллээ. Үүнд: – “Гавьяат эдийн засагч” -1; – “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор - 4; – “Алтангадас одон”-оор -12; – “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар - 7; – Салбарын шагналаар - 15; – ТӨБЗГ-ын “Жуух бичиг”-ээр - 7 албан хаагч шагнуулсан байна. Төрийн өмчийн эзэмшил, ашиглалтыг сайжруулах үйлсэд оруулсан хувь нэмрийг үнэлж, төрийн өмчит компанийн 22 ажилтныг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шагналаар шагнасан. 2021 оны батлагдсан төсвийн хүрээнд 49 албан хаагчийн хоол, унааны нэмэгдлийг нэмж, хүний нөөцийн системд оруулсан. (100.0 хувь)
Арга хэмжээ 15.5. (61) Албан хаагчдын хувийн хэргийн баяжилт хийх, хүний нөөцийн бүртгэл, хөдөлгөөний тайланг гаргах	4.2 сая	- Хувийн хэргийн баяжилт хийгдсэн байх; - Хүний нөөцийн бүртгэл, судалгааг хийсэн байх; - Хүний нөөцийн шилжилт, хөдөлгөөн, албан хаагчдын тоогоор;	32 албан хаагчдын хувийн хэргийн баяжилт хийж, хүний нөөцийн бүртгэлд 32 албан хаагчийн мэдээллийг шинээр оруулсан.	- Албан хаагчдын хувийн хэргийн бүрдэл хангагдсан байна; - Хүний нөөцийн бүртгэлийг хуулийн хугацаанд цахим санд оруулан мэдээлсэн	II-IY улирал, ЗУХ	Засгийн газрын “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 144 дүгээр тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэг өөрчлөгдөж, зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан нийт 40 албан хаагчийн хувийн хэрэгт нөхөн бүрдүүлэлт, баяжилт хийв. Үүнд: – Шинээр томилогдсон – 24; – Ажиллаж байсан – 16 албан хаагч. Тайлант хугацаанд 24 иргэнийг албан тушаалд

		- Холбогдох мэдээ, тайланг ТАЗ, ЗГХЭГ-т хүргүүлэх.		байна; - Холбогдох тайлан, мэдээ, судалгааг ТАЗ, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.		томилж, 2 албан хаагч өөрийн хүсэлтээр албан тушаалаас чөлөөлөгдсөн байна. Үүнд: – Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтаар – 8 албан хаагч; – Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3, Коронавируст халдвар /Ковид -19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтаар – 2 албан хаагч; – Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 27.3 дахь заалтаар – 4 албан хаагч; – Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалтаар – 1 албан хаагч; – Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалтаар – 2 албан хаагч; – Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 23 дугаар зүйлийн 23.2.3, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтаар – 1 албан хаагч; – Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, 23 дугаар зүйлийн 23.2.1 дүгээр заалт, 24 дүгээр зүйлээр – 6 албан хаагч; – Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4 дэх заалтаар – 1 албан хаагч; – Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1 – 1 албан хаагч; Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системд байршсан бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг албан хаагчтай холбоотой тушаал шийдвэр гарсан өдрөөр нь холбогдох мэдээллийг оруулж байна.

						(100.0 хувь)
Арга хэмжээ 15.6. (62) Албан хаагчдын дунд ёс зүйн хэм хэмжээг сахиулах, аливаа зөрчил, дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулах	2.2 сая	- Ёс зүйн зөвлөлийг өөрчлөн байгуулах; - Холбогдох дүрэм, журмын хэрэгжилт, хувиар.	Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн албан хаагч байхгүй.	- Ёс зүйн зөвлөлийг өөрчлөн байгуулсан байна; - Холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулсан байна; - Хэрэгжилтийг тайлагнасан байна, хэрэгжилт – 90< хувь байна.	II-IY улирал, ЗУХ	Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулсан. Тус сургалтад 35 албан хаагч хамрагдсан. Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйл 37.1.7 дахь хэсэгт төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх”, ТӨБЗГ-ын хөдөлмөрийн дотоод журмын 7.2.3-т “төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх үүрэгтэй” гэснийг зөрчиж, ёс зүйн зөрчил гаргасан 1 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан. Байгууллагын ёс зүйн зөвлөлийн тайланг улирал бүр Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв. (100.0 хувь)
Арга хэмжээ 15.7. (63) Албан хаагчдын дунд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	1.0 сая	- “Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах комисс” байгуулан ажиллуулах; - Олон нийтийн арга хэмжээг төлөвлөн зохион байгуулсан байх; - Хэрэгжилтийн хувь.	Коронавирусын халдвар (Ковид-19)-ын цар тахлын нөхцөл байдал, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэг зарласантай холбоотойгоор олон нийтийн арга хэмжээ зохион байгуулагдаагүй.	- Комиссыг шинэчлэн байгуулсан байна; - Албан хаагчдын дунд зохион байгуулах олон нийтийн арга хэмжээг төлөвлөн зохион байгуулсан байна; - Төлөвлөгөөний хэрэгжилт – 100 хувь байна.	II-IY улирал, ЗУХ, Олон нийтийн арга хэмжээ зохион байгуу-лах комисс	Монгол Улсад иргэний өмчлөх эрх хуулиар баталгаажиж, хэрэгжиж эхэлсний 30 жил, Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага үүсэж хөгжсөний 25 жилийн ойн арга хэмжээг Захиргаа, удирдлагын хэлтэс, Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах комисстой хамтарч зохион байгуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар улс орон даяар хэрэгжүүлж буй “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-д 34 албан хаагч оролцож, 80 ширхэг модыг Сонгино Хайрхан дүүргийн Баруун салаан дахь Гүнжийн булаг цэцэрлэгт тарьсан. (100.0 хувь)

Стратеги төлөвлөгөөний зорилго 15. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, журам, стандарт, зааврын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.						
Зорилт 16. **Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын баримтын хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалтын үйл ажиллагааг сайжруулна.**	**31.8 сая**	**Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байх.**	**Бүтэц, орон тоо хангалтгүй байсан.**	**Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, заавар журам, стандарт хэрэгжилтэд ахиц гарсан байна.**	**I-IY улирал,** **ЗУХ**	**Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг тооллогоос өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, архивын баримтын хадгалалт, хамгаалалтыг стандартыг хангах арга хэмжээ авч ажиллалаа.** **Байгууллагын 2020 оны баримтын нөхөн бүрдүүлэлтийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу, архив, албан хэрэг хөтлөх үндсэн зааврын хүрээнд хийсэн.** **Хугацаатай албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дотоод хяналт тавьж ажиллав.** **(95.0 хувь)**
Арга хэмжээ 16.1. (64) Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулалтаар хангах, албан бичгийн шийдвэрлэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулах	9.5 сая	- Албан хэрэг хөтлөлтийн заавар, стандартыг хангуулах; - Албан хаагчдыг мэргэжил, арга зүйгээр хангах; - Хяналт хийж, зөрчил, доголдлыг арилгах; - Хугацаатай албан бичгийн шийдвэрлэл-тийн хувь.	Хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт 97.7 хувь байсан.	- Албан бичиг, хэргийн эргэлтийн мэдээ тайланг гаргаж, дүгнэлт хийсэн байх; - Заавар, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авсан байна; - Хариутай бичгийн шийдвэрлэл-тэд хяналт тавьж хугацаанд нь шийдвэрлүүл-сэн байна;	I-IY улирал, ЗУХ	2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт нийт 5252 албан бичиг хүлээн авснаас 1247 буюу 47.2 хувь нь хариутай, 2479 буюу 52.8 хувь нь хариу өгөх шаардлагагүй албан бичиг ирснийг дотоод сүлжээний https://www.able.mn цахим системд бүртгэн удирдлагуудад танилцуулж, холбогдох албан хаагчдад хүргүүлэн шийдвэрлүүлж байна. Тайлант хугацаанд 2479 хариутай албан бичгээс 2304 буюу 92.94 хувь нь хугацаандаа шийдвэрлэгдэж, 64 буюу 7.1 хувь нь хугацаандаа шийдвэрлэгдээгүй удааширч байна. Бусад байгууллага, аж ахуй нэгж, иргэнд тайлант хугацаанд нийт 2117 албан бичгийг хүргүүлсэн. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 80, хүний нөөцийн холбоотой 71, нийт 151 тушаал албажин гарсан байна. Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын 4.1.3; 4.1.5 дахь хэсэг, 2021 онд хяналт-шинжилгээ,

				- Хэрэгжилтийг 90< хувьд хүргэсэн байна.		үнэлгээ, дотоод аудит хийх төлөвлөгөөг үндэслэн албан бичгийн шийдвэрлэлтэд дотоод хяналтыг 2021 оны эхний хагас жилийн байдлаар болон III улирлын байдлаар тус тус хийсэн. 2021 оны эхний хагас жилийн байдлаар 1247 хариутай албан бичгээс 1155 буюу 92.6 хувь нь хугацаандаа шийдвэрлэгдэж, 92 буюу 7.4 хувь нь шийдвэрлэгдээгүй хугацаа хэтэрсэн байна. III улирлын байдлаар ТӨБЗГ-т ирсэн 1783 хариутай албан бичгийн шийдвэрлэлт 97.87 хувьтай, хугацаа хоцорч шийдвэрлэсэн албан бичиг 721 буюу шийдвэрлэсэн бичгийн 41.32 хувь эзэлж байгаа асуудлыг анхаарахтай холбоотой зөвлөмжийг удирдлага, албан хаагчид өгч ажилласан байна. Дотоод хяналтын ажлын дүнгээр албан бичгийн шийдвэрлэлт эхний хагас жилд 92.62 хувьтай, хугацаа хэтэрсэн 92 албан бичиг байсан бол III улиралд шийдвэрлэлт 97.87 хувь буюу 21 албан бичгийн шийдвэрлэх хугацаа хэтэрсэн нь өмнөх улиралтай харьцуулахад шийдвэрлэлт өссөн үр дүнтэй байв. Дотоод хяналтаар илэрсэн зөрчил, анхаарах асуудлыг засах талаар холбогдох зөвлөмж бүхий тайлан, танилцуулгыг нийт албан хаагчдад дотоод сүлжээгээр болон удирдлагын шуурхай хурлаар дамжуулан хүргэсэн. (100.0 хувь)
Арга хэмжээ 16.2. (65) Архив, албан хэргийн хөтлөлтийн тухай хууль, Байгууллагын архивын ажлын үндсэн зааврын хэрэгжилтийг хангах, Баримт бичгийн нягтлан шалгах комиссын ажлыг эрчимжүүлэх	9.5 сая	- Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлах; - Баримт материалыг зааврын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулах;	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 50 баримт хүлээн авч, хадгаламжийн нэгжийн данс, бүртгэл хийсэн.	- 2021 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн баталсан байна; - 2020 оны баримтыг архивд хүлээн авч, хадгаламжийн	I-IY улирал, ЗУХ	ТӨБЗГ-ын даргын 2021 оны А/5 дугаар тушаалаар байгууллагын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах комисс (ББНШК)-ыг шинэчлэн байгуулж, дүрмийг батлан мөрдүүлж байна. ББНШК-ын хурлаар 2021 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг шинэчлэн батлуулж, мөрдүүлсэн. Хэлтэс, алба, албан хаагчдаас хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2020 оны архивын баримт материалыг архивд хүлээн авах ажлыг зохион байгуулсан бөгөөд нийт 120 баримтыг архивын

		- Архивын хадгаламжийн нэгжийн данс бүртгэл, техник ажиллагааг стандартын дагуу үйлдсэн байх; - Баримт бичгийн нягтлан шалгах комиссыг журмын дагуу ажиллуулах.		нэгжийг бүрдүүлж, данс бүртгэл хөтлөн дүн мэдээг тайлагнасан байна; - Баримт бичгийн нягтлан шалгах комиссыг холбогдох журмын дагуу ажиллуулах.		үндсэн заавар, стандартын дагуу эмхэлж, техник ажиллагааг хийн данс бүртгэлд тусгасан. (100.0 хувь)
Арга хэмжээ 16.3. (66) “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ийн дүнгийн мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлэх	6.4 сая	- Хэрэгжүүлэх арга хэмжээг холбогдох нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх; - Хэрэгжилтэд хяналт тавих; - Албан хаагчдыг шаардлагатай мэдээлэл, мэргэжил, арга зүйгээр хангах; - Үр дүнг тооцсон байх.	2020 онд Архивын ерөнхий газраас сургалт зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангасан.	- Авах арга хэмжээг нэгж, албан хаагчдад сурталчлан мэдээлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна; - Тодорхой эерэг үр дүн гарсан байна.	II-IY улирал, ЗУХ, Бусад хэлтэс, алба	2020 оны ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдол болох баримтуудад техник боловсруулалт хийж, үдэж хавтаслан данс бүртгэлд тусгасан. “Байгууллагын архивын үндсэн заавар”-ын 7.3-д заасны дагуу түүхчилсэн лавлах үйлдэж байна. Архивын өрөөнд хадгаламжийн нэгжээс өөр эд зүйлс байрлуулахгүй байх, Хууль зүйн сайдын 2015 оны А/224 дүгээр тушаалаар батлсан “Архивын байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм”-д нийцүүлэн ажиллаж байна. “Байгууллагын архивын үндсэн зааврын “Архивын баримтыг хүлээн авахдаа “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 3.3, 3.4 дэх хэсэгт заасан шаардлагын дагуу бүрдүүлсний дараа хүлээн авч байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын архивын хадгаламжийн нэгжээс лавлагаа үйлчилгээ үзүүлэх хүрээнд 13 баримтыг ашиглалтад бүртгэлээр олгож, 700 хуудас бүхий 17 баримтад “Хуулбар үнэн” тухай тэмдэглэгээ хийж үйлчилсэн байна. (90.0 хувь)

Арга хэмжээ 16.4. (67) Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, судлан шийдвэрлэж, хариу өгөх, тайлагнах	6.4 сая	- Холбогдох хуулийн дагуу судлан шийдвэрлэсэн байх; - Шийдвэрлэлтийн хувь; - Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн нэгдсэн тайланг нээлттэй мэдээлсэн байх.	2020 онд 141 өргөдөл, гомдлыг хүлээн авч 127 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн. Шийдвэрлэлт 90.1 хувь.	- Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариу өгсөн байна; - Нэгжүүдээс өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг гаргасан байна; - Байгууллагын нэгдсэн тайланг гаргаж, дүгнэлт хийсэн байна; - Тайланг ил тод, нээлттэй мэдээлсэн байна.	I-IY улирал, ЗУХ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 162 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирсэн байна. Үүнээс шийдвэрлэсэн өргөдөл 86.79 хувь буюу 138, хугацаа хэтэрсэн өргөдөл 10, хяналтад байгаа өргөдөл 11 байгаа бөгөөд тодорхой шалтгааны улмаас шийдвэрлэлт удааширсан байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудын хүрээнд шийдвэрлэж байгаа эсэхэд хяналт тавих, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор тус байгууллага, түүний албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн нийт 57 өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтэд 2021 оны I улирлын байдлаар дотоод хяналтыг хийхэд 39 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 11 өргөдөл, гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй, 6 өргөдөл, гомдол шийдвэрлэгдээгүй дүнтэй байсанд дүгнэлт хийж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, тайланг байгууллагын удирдлагуудад танилцуулан, байгууллагын дотоод сүлжээ https://www.able.mn -ний цахим сангийн “Дотоод хяналт” цэсэнд байршуулж, албан хаагчдыг мэдээллээр хангаж ажиллав. (90.0 хувь)
Стратеги төлөвлөгөөний зорилго 16. Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын оновчтой удирдлагыг хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана.						
Зорилт 17. **Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг**	**31.8 сая**	- **Аудитын зөвлөмжийн хэрэгжилт, хувиар;**	**2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын**	- **2020 оны санхүүгийн тайланд хийсэн**	**I-IY улирал,** **ЗУХ**	**2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4 акт, 3 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн. Үүнээс: “Хөдөө аж ахуйн бирж” ХХК,**

оновчтой төлөвлөж, тэвчиж болох зардлыг хэмнэх, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.		- **Аудитын санал дүгнэлт.**	**дүнгээр “Зөрчилгүй” санал дүгнэлттэй дүгнэгдсэн.**	**аудитын зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь;** - **“Зөрчилгүй” санал дүгнэлт бүхий үнэлгээтэй байна.**		**“Улаанбаатар төмөр зам” ХНН, “Эрдэнэс Монгол” ХХК, “Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв”** **ТӨҮГ гэсэн төрийн өмчит 4 хуулийн этгээдэд Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д “Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.5.1-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1.-д зааснаас бусад төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг”, Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 315 дугаар тогтоолын хэрэгжилтийг хэрэгжүүлж ажиллаагүй нийт 3,737,503.0 мянган төгрөгийн акт тавигдсанаас 2,580,273.1 мянган төгрөгийг нөхөн төвлөрүүлсэн.** **“Төрийн өөрийн эд хөрөнгийг түрээслэх журам”-ын дагуу иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан эд хөрөнгө түрээслэх гэрээний дагуу улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогыг цаг тухайд бүртгээгүй авлага, өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүйгээс 2021 оны хагас жилийн тайланд түрээслэгч иргэн, аж ахуйн нэгжийн түрээсийн орлогыг цаг тухайд бүртгэн авлага өглөг үүсгэн санхүүгийн тайланд тусгалаа. Шилэн дансны тухай хуулийн хүрээнд хуулийн хугацаанд мэдээллийг оруулж байна.** **Зөвлөмжийн хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд авлага, өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулах, бараа материалыг бүртгэлд зөв тусгах зэрэг зөвлөмжийг мөрдөж ажилласан.** **Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөж, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдлөг болгон зардлыг зардлын ангиллаар, төсвийн хуваарийн дагуу хэмнэлттэй**

						зарцууллаа. (98.0 хувь)
Арга хэмжээ 17.1. (68) Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтлөх	7.4 сая	- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж, батлуулах; - Аудитын зөвлөмжийн хэрэгжилт, хувиар; - Өр, авлагагүй байх.	2019 оны аудитын зөвлөмжийн хэрэгжилт 64.0 хувь, төлбөрийн акт 53.3 хувь, албан шаардлага 80.0 хувийн гүйцэтгэлтэй байна.	- Бодлогын баримт бичгийг батлуулан мөрдүүлсэн байна; - Батлагдсан төсвийг хуваарийн дагуу зарцуулж, өр, авлага үүсгээгүй байна; - Санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан цаглабарын дагуу гаргаж, Төсвийн ерөнхийлөн захирагчид болон холбогдох байгууллагад тайлагнасан байна.	I-IY улирал, ЗУХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18, 20 дугаар зүйлд заасны дагуу Үндэсний аудитын газрын 2020 оны зөвлөмжийг хэрэгжүүлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/76 дугаар тушаалаар батлан мөрдүүлэх арга хэмжээг авааД байна. 2021 оны төсвийн хуваарийн дагуу санхүүжилтийг авч, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор өгсөн хэмнэлтийн горимоор ажиллах үүрэг даалгаврыг мөрдлөг болгон ажилласан. Холбогдох байгууллагад хүргүүлсэн төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээ (2021.12.01-ний байдлаар): – Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүр гаргаж, ЗГХЭГ-т сар бүрийн 2-ны дотор хүргүүлэв; – 1-11 сарын албан хаагчдын цалинг төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланд үндэслэн тооцож, Нийгмийн даатгал, Татварын тайланг гарган тус тус холбогдох байгууллагад хүргүүлсэн; – Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос албан татвар ногдох орлогыг суутган I, II, III улирлын ХАОАТ-ын тайланг гаргаж хуулийн хугацаанд цахимаар илгээсэн. Тайлант хугацаанд хийгдсэн санхүүгийн гүйлгээний анхан шатны баримтын бүрдлийг тухай бүр ханган бүрдүүлж ажиллалаа. (100 хувь)
Арга хэмжээ 17.2. (69)	4.2 сая	- Оруулсан мэдээллийн	2020 онд шилэн	- Хууль тогтоомжид	I-IY улирал,	Хууль тогтоомжоор тогтоосон, шилэн дансанд байршуулах байгууллагын батлагдсан төсөв,

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд цахим системд нээлттэй байршуулан мэдээлэх		тоо; - Хэрэгжилтийн хувь.	дансанд 151 мэдээлэл оруулахаас 124 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн, 25 мэдээллийн хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийн хугацаа болоогүй. Хэрэгжилт 83.22 хувь.	заасан хугацаанд 151 мэдээллийг шилэн дансанд нээлттэй байршуулна; - Хэрэгжилтийг 100 хувь хангаж ажилласан байна.	ЗУХ	худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн шалгалтын аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж, сар, улирал, жилийн төсвийн гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлт, өмч хөрөнгө захиран зарцуулах шийдвэр зэрэг 112 мэдээллийг 2021 оны 2 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн хугацаа хоцроолгүй байршуулан, нээлттэй мэдээлсэн байна. (90.0 хувь)
Арга хэмжээ 17.3. (70) 2022-2024 оны төсвийн төсөөлөл, 2022 оны төсвийн төсөл, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал боловсруулж, Төсвийн ерөнхийлөн захирагч болон Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлэх	3.2 сая	- Судалгаа, тооцоололд үндэслэн төсвийн төслийг үнэн зөв үндэслэлтэй боловсруулах; - Аргачлал, заавар журамд нийцсэн байх; - Нэгжүүдээс санал авсан байх; - Хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлсэн байх.	2020 оны үйл ажиллагааны зардалд 1,254.7 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэл 1,027.1 сая төгрөг байна.	- Нэгжүүдээс 2022 онд зохион байгуулах арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоо, хөрөнгө оруулалтын төсөлд тусгах саналын хамт авч, төсвийн төсөлд тусгасан байна. - Төсвийн төслийн саналыг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор холбогдох газар	III улирал, ЗУХ, Бусад хэлтэс, алба	2022 оны Төсвийн төсөлд шинээр тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлтэс, албанаас авч боловсруулан Сангийн яам, ЗГХЭГ-т 2021 оны 04 сарын 26 өдөр албан бичгээр болон https://www.publicinvestment.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2022 оны төсвийн төлөвлөгөө, 2023-2024 оны төсвийн төсөөллийг удирдамжийн дагуу боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагч болон Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд ТӨБЗГ-ын 2022 оны төсөв 3,360.7 сая төгрөгөөр батлагдсан үр дүнтэй байна. Үүнд: – Хөрөнгө оруулалтын зардалд Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн систем, тоног төхөөрөмж худалдан авахад 1,200.0 сая төгрөг; – Сангийн сайдын 2019 оны 74 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын дагуу Төрийн өмчийн

				хүргүүлсэн байна.		бодлого, зохицуулалтын газрын 2021 оны үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах зөвшөөрлийг хянуулж шийдвэрлүүлэв. (100 хувь)
Арга хэмжээ 17.4. (71) Нийгмийн даатгалын шимтгэл, татвар, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн мэдээ, тайланг гаргаж, тайлагнах	6.4 сая	- Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан цаглабарын дагуу мэдээ, тайланг гаргаж, холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэх; - Хэрэгжилтийн хувь.	Тайланг хуульд заасан цаглабарын дагуу тайлагнасан.	- Тайланг хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. - Өр, авлага үүсгэлгүй тайлагнасан байна. - Албан хаагчдын нийгмийн даатгалын дэвтрийн бичилт хийгдэж, баталгаажуул-сан байна.	I-IY улирал, ЗУХ	Тайлант хугацаанд санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлсэн. ТӨБЗГ нь 2020 оны аудитын зөвлөмжийн дагуу Төрийн өмчийг түрээсэлсэн орлогын бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтөлснөөр 451.2 сая төгрөгийн авлага, 192.2 сая төгрөгийн өглөгтэй гарсан. Нийгмийн даатгалын дэвтэрт 2021 оноос гарын үсэг зурж баталгаажуулахгүй болж, цахим хэлбэрт шилжсэн. Сар бүрийн нийгмийн даатгалын тайланг НД7, НД8 маягтын дагуу гарган холбогдох байгууллагад хүргүүлэн баталгаажуулалт хийлгэж хэвшсэн. (100 хувь)
Арга хэмжээ 17.5. (72) ТӨБЗГ-ын үндсэн хөрөнгийн бүртгэл тооллогыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт	10.6 сая	- Үндсэн хөрөнгийн тооллогыг хийж, үр дүнг тайлагнасан байх; - Тооллогын дүнг санхүүгийн	2020 онд тооллого хийж, бүртгэлийг шинэчлэн, санхүүгийн тайланд тусгасан.	- Эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, бүртгэлийг шинэчилсэн байна; - Ашиглалтын хугацаа дуусан,	ЗУХ	Байгууллагын үндсэн хөрөнгийн тооллогыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/52 дугаар тушаалаар байгуулж, тооллогыг 2021 оны 06 дугаар сарын 25-30-ны өдрийн хооронд зохион байгуулав. Тооллогоор барилга байгууламж 2,751,191,680.0 төгрөг, авто тээврийн хэрэгсэл 378,343,703.57 төгрөг, машин тоног төхөөрөмж 364,129,969.0 төгрөг, тавилга эд хогшил 297,884,779.0 төгрөг, биет бус хөрөнгө

тавих		тайланд тусгасан байх.		цаашид ашиглагдахгүй болсон эд хөрөнгийн жагсаалт гаргаж, газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах; - Бүртгэл, тооллогын дүнг санхүүгийн тайланд тусгасан байна.		84,720,400.0 төгрөг, нийт 3,876,270,531.81 төгрөгийн 1053 ширхэг эд хөрөнгө тоологдсон бөгөөд дүнг санхүүгийн тайлан баланстай тулган баталгаажуулаа. Үндсэн хөрөнгийг бүрэн бүртгэлжүүлэх, коджуулах ажил хийгдсэн. 2021 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/77 дугаар тушаалаар байгуулаад байна. Жилийн эцсийн тооллогыг 2021 оны 12 дугаар сарын 13-17-ны өдрүүдэд зохион байгуулж, дүн, тайланг нэгтгэхээр хүлээгдэж байна. (100 хувь)
Стратеги төлөвлөгөөний зорилго 17. Мэдээллийн технологийн ололтыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж, цахим шилжилтийн бодлогыг хэрэгжүүлэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах менежментийг сайжруулж, чадавхыг дээшлүүлнэ.						
Зорилт 18. **Байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийн дэд бүтцийг хөгжүүлж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангана.**	**75.8 сая**	- **Техник, технологийн шинэчлэл хийх;** - **Нэвтрүүлсэн цахим үйлчилгээ, тоогоор.**	**Цахим 3 үйлчилгээг ашиглаж байна.**	- **Судалгаа хийгдсэн байна;** - **Файл сервер, судалгааны сан, удирдлагын хяналтын системийг бүрэн ашиглалтад оруулсан байна.**	**I-IY улирал,** **МТА**	**Байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийн хөгжүүлэлтэд хийх судалгааг гарган ТӨБЗГ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар 7 мэдээлэл, нэвтрүүлгийг хийж ажилласан.** **Тайлант хугацаанд 2 видео мэдээ, уулзалт зөвлөгөөн зэрэг өдөр тутмын үйл явдалтай холбоотой нийт 9 мэдээ, мэдээллийг https://pcsp.gov.mn вэб сайтад, ТӨБЗГ-ын фэйсбүүк пэйж, TV5, NTV телевизүүдээр тухай бүр шуурхай мэдээлэн сурталчилж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллалаа. (97.5 хувь)**
Арга хэмжээ 18.1. (73) Серверийг сүлжээнд холбох	22.7 сая	Холбогдсон эсэх	Сервер сүлжээнд холбогдоогүй.	Серверийг сүлжээнд холбож, хэвийн ажиллагаатай болгосон байна.	I-III улирал, МТА	Ашиглагдахгүй байгаа 2 серверийг 1.3 сая төгрөгийн санхүүжилтээр шинэчлэн тохируулж, windows 2022 систем суулган хэвийн үйл ажиллагаатай болгосон. (100 хувь)

Арга хэмжээ 18.2. (74) Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгох ажлын хүрээнд бэлтгэл ажлыг хангах, санхүүжилтийг шийдвэрлүүлэх	18.9 сая	- Шаардлагатай хөрөнгийн тооцоо хийж, төсөл боловсруулсан байх; - Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авсан байх.	Нэгдсэн систем технологийн хоцрогдолд орж, ажиллахгүй болсон. Мэдээллийн нэгдсэн системийг бий болгох асуудал Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.	- Программ хангамжийг сайжруулах төлөвлөгөө батлуулсан байна; - Судалгаа, тооцоолол хийгдсэн байна; - Мэдээллийн нэгдсэн системд шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг холбогдох газраар шийдвэрлүүлсэн байна.	I-IY улирал, МТА, ТӨБАХ, ЗУХ	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг боловсруулах суурь судалгааг бүрэн хийж, 2022 оны улсын төсөвт 1.2 тэрбум төгрөгийг тусгуулах арга хэмжээ авсны дүнд тухайн төсөвт өртөг батлагдсан. Системийг хийж боловсруулах ажлын даалгаврыг 2022 оны 1 сард бэлэн болгоно. (100 хувь)
Арга хэмжээ 18.3. (75) Байгууллагын дотоод сүлжээний программ хангамжийг сайжруулах	15.3 сая	- Мэдээллийн сангийн багтаамж; - Хэрэглэгчийн тоо.	Вэб хандалт бүхий https://www.able.mn системийг ашиглаж байгаа. Дотоод сүлжээнд мэдээллийн сан үүсээгүй.	Байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн сан үүсгэсэн байна.	I-IY улирал, МТА	Байгууллагын хэмжээнд ашиглаж буй төрийн байгууллагын дотоод системтэй холбоотой албан хаагчдад тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд тухай бүр нь зөвлөгөө өгч, шинээр томилогдсон албан хаагчдын мэдээллийг цахим системд бүртгэлжүүлэн эрх үүсгэн шийдвэрлэсэн бөгөөд төрийн албан бичиг солилцооны https://docx.gov.mn системтэй холбосон. Шинээр ажилд томилогдсон албан хаагчдад дотоод сүлжээний сургалтыг https://www.able.mn системийн удирдлагуудтай хамтран зохион байгуулсан. Тайлант хугацаанд шинээр 16 хэрэглэгчийн эрх үүсгэж 1 хэрэглэгчийн эрхийг хассан. Мэдээллийн сан хадгалах серверийг байршуулан

						систем суулгаж, байгууллагын дотоод мэдээллийн санг үүсгэж эхлээд байна. (100 хувь)
Арга хэмжээ 18.4. (76) Байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангах	18.9 сая	- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх; - Цахим хуудасны хөгжүүлэлт хийх; - Олон нийттэй харилцах ажлын менежментийг сайжруулсан байх.	Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг сайжруулах шаардлагатай.	- Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авсан байна; - Мэдээллийн нээлттэй байдлыг хангах сувгийн тоог нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулсан байна.	I-IY улирал, МТА	Байгууллагын албан ёсны цахим хуудас https://pcsp.gov.mn/ болон фэйсбуук пейж, байгууллагын мэдээллийн самбарт холбогдох мэдээллүүдийг тухай бүр байршуулан нээлттэй мэдээлж байна. Байгууллагын хуралдаанаас гарсан тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, төрийн өмчит хуулийн этгээдүүдтэй холбоотой мэдээ, мэдээлэл, эд хөрөнгийн өөрчлөлт, зохицуулалтын талаарх мэдээллийг дотоод сүлжээ болон байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулан мэдээлэв. Байгууллагын https://pcsp.gov.mn/ мэдээллийн сайтыг бүрэн шинэчилсэн. Газрын хуралдааны мэдээлэл солилцооны https://share.come.mn системийг шинээр бий болгон үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн. Цаг үеийн мэдээ мэдээллийг 5 телевиз, 10 сайтаар мэдээлэн хүргэсэн. Монгол Улсад өмчийн хувьчлал эхэлсний 30 жил, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгуулагдсаны 25 жилийн ойд зориулсан тусгай дугаарыг VIP76 сэтгүүлтэй хамтран хийж хэвлүүлэн олны хүртээл болгосон. (90 хувь)
Стратеги төлөвлөгөөний зорилго 18. Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, хуулийн хэрэгжилтэд хяналт тавина.						
Зорилт 19 **Хууль, эрх зүйн**	**21.0 сая**	- **Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаан**	**2020 онд хууль, эрх зүйн нэгжийн чадавх**	**Албан хаагчид, хэрэглэгч, оролцогчдын**	**II-IY улирал,**	**Нийт албан хаагчийн дунд 7 сэдвээр хууль, эрх зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгаа, хууль таниулах ажлыг зохион байгуулсан бөгөөд 4**

сургалт, сурталчилгааны ажлын чанарыг сайжруулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих ажлыг зохион байгуулна.		**ы хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалт, сурталчилгааг зохион байгуулах;** **- Зарим хуулийн хэрэгжилтэд хяналт тавих.**	**сул байсан.**	**ТӨБЗГ-ын үйл ажиллагаанд хамааралтай хууль, эрх зүйн мэдлэг, ойлголт сайжирна.** **Хуулийн зөв хэрэглээ тогтоно.**	**ХЭЗХ**	**аймгийн Орон нутгийн өмчийн газарт хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, эрх зүйн туслалцаа үзүүлсэн байна.** **Төрийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төв, орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, албан хаагчдад төрийн болон орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой хууль, эрх зүйн зөвлөгөөг тогтмол өгсөн.** **(100 хувь)**
Арга хэмжээ 19.1. (77) Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	15.7 сая	- Сургалтын хэрэгцээг тодорхойлсон байх; - Хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан батлуулсан байх; - Сургалтад хамрагдсан байгууллага, албан хаагчдын тоо.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 1996 онд батлагдсан хуулийг мөрдөж байна. Дагалдах 17 журам, зааврууд ыг төрийн өмчит хуулийн этгээдэд мөрдүүлж байна.	Сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсны дагуу батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан байна.	II-IY улирал, ХЭЗХ, бусад хэлтэс, алба	ТӨБЗГ-ын албан хаагчдын ажил үүрэг гүйцэтгэхдээ анхаарах зарим асуудлаар дараах 7 сэдвийн хүрээнд эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулав: 1. Төрийн байгууллага мэдээллийн ил тод байдлыг хэрхэн хангах вэ; 2. Албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтын тухай; 3. Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахад анхаарах асуудал тухай; 4. Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт; 5. Давхар ажил эрхлэлттэй холбоотой журам, хязгаарлалт; 6. Өршөөлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан нийт албан хаагчдад замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн талаар болон өршөөлийн тухай хуульд хамааруулахгүй зөрчлийн талаар; 7. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын онцлог зохицуулалтын тухай. Тайлант хугацаанд өмчийн харилцааны асуудлаар Хөвсгөл, Дорнод, Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газарт хууль эрх зүйн тайлбар, зөвлөгөө өгч, нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн байгууллагын албан хаагчдад эрх зүйн сургалт хийв. Мөн баруун бүсийн авто зам засвар, арчлалтын 4 компанийн эрх бүхий албан хаагчдад авлигын эсрэг

						хууль тогтоомжид заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлэх асуудлаар семинар хийж, эрх зүйн зөвлөгөө өгөв. (100 хувь)
Арга хэмжээ 19.2. (78) Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хэрэгжүүлж байгаа хуулийн хэрэгжилтэд хяналт тавих	5.3 сая	- Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулсан байх; - Хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр авсан арга хэмжээ, тоогоор.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 1996 онд батлагдсан хуулийг мөрдөж байна.	Зарим хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналтын мөрөөр авах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжилтийг хангуулсан байна.	II-IY улирал, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, ЗУХ	(ХБ)
Стратеги төлөвлөгөөний зорилго 19. Захиргааны акт, баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлж, зөвлөгөө, арга зүйгээр хангана.						
Зорилт 20. **Хууль, эрх зүйд нийцсэн захиргааны акт, баримт бичгийг боловсруулж, албажуулна.**	**12.6 сая**	**Хууль, эрх зүйд нийцсэн байх шаардлагыг хангасан баримт бичгийг боловсруулсан байх.**	**2020 онд 6016 баримт материалын эрх зүйн үндэслэлийг хянаж, хуульд нийцүүлсэн. Хууль, эрх зүйн зөвлөгөө, арга зүйгээр тухай бүр хангасан.**	**Холбогдох зөрчил, хэрэг маргаан үүсч, буруутай нь тогтоогдоогүй байна.**	**I-IY улирал,** **ХЭЗХ**	**ТӨБЗГ-ын 595 тогтоол, 34 тэмдэглэл, 145 тушаал, 2030 албан бичиг, 12 гэрээ, 6 компанийн дүрмийн хууль, эрх зүйд нийцсэн байдлыг хянан, зөвлөгөө, арга зүйгээр ханган ажилласан.** **Хууль, эрх зүйд нийцээгүй захиргааны шийдвэр гаргасан зөрчил үүссэн талаар хууль, хяналтын байгууллагаас дүгнэлт гаргасан тохиолдолгүй байна. (100 хувь)**
Арга хэмжээ 20.1. (79) Байгууллагын тогтоол, тушаал, албан бичиг, гэрээ, контракт зэрэг баримт бичгийн хууль эрх зүйн үндэслэлийг	12.6 сая	- Хянасан баримт бичгийн төрөл, тоо; - Зөвлөгөө, арга зүйгээр хангасан тоо;	6016 баримт бичгийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянасан.	- Хууль, эрх зүйн зөрчилтэй шийдвэр, баримт бичиг гараагүй байна. (Холбогдох	I-IY улирал, ХЭЗХ	ТӨБЗГ-ын 21 удаагийн хуралдаанаар хэлэлцсэн 595 тогтоол, 34 тэмдэглэл, ТӨБЗГ-ын даргын “А” тушаал 78, “Б” тушаал 67, нийт 774 шийдвэрийн төслийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянасан. Тайлант хугацаанд байгууллага, аж ахуйн нэгж,

хянаж, арга зүйгээр хангах		- Хянасан баримт бичгийн бүртгэл хөтөлсөн байх.		байгууллагын дүгнэлтийг үндэслэх); - Албан хаагчдыг зөвлөгөө, арга зүйгээр хангасан байна; - Бүртгэлжүүл-сэн тоо баримтаар тооцно.		иргэдэд ТӨБЗГ-аас хүргүүлсэн нийт 2030 албан бичгийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж, санал, зөвлөгөө өгсөн байна. ТӨБЗГ-тай тодорхой чиглэлээр хамтран ажиллах асуудлаар байгуулсан нийт 12 гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, гэрээний бүртгэлийг хөтлөн ажиллав. Зарим төрийн өмчит дараах компани, үйлдвэрийн газрын дүрмийг хууль эрх зүйд нийцүүлэн хянав: – “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” ТӨҮГ; – “Геологийн төв лаборатори” ТӨҮГ; – “Геологийн судалгааны төв” ТӨҮГ; – “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ; – “Багануур АЗЗА” ТӨХК; – “Монголын төмөр зам” ТӨХК зэрэг. Хууль, эрх зүйн зөрчилтэй шийдвэр гаргасан талаар эрх бүхий байгууллагын дүгнэлт гараагүй. (100 хувь)
Стратеги төлөвлөгөөний зорилго 20. Хууль, хяналтын байгууллагад хянагдаж байгаа хэрэг, маргааны шийдвэрлэлтэд байгууллагыг төлөөлөн оролцож, хууль ёсны эрх ашгийг хамгаална.						
Зорилт 21. **Хууль, хяналтын байгууллагад ТӨБЗГ-ын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хамтран ажиллана.**	**45.2 сая**	- **ТӨБЗГ-ын хууль ёсны эрх ашиг хамгаалагдсан байх.**	**2020 онд нийт 24 хэрэг, маргаан хянагдаж, 7 хэрэг эцэслэн шийдвэрлэгд-сэн.**	- **ТӨБЗГ-ын хууль ёсны эрх ашиг хамгаалагд-сан байна;** - **Холбогдох албан тушаалтанд эрх зүйн туслалцаа үзүүлсэн байна.**	**I-IY улирал,** **ХЭЗХ**	**Захиргааны 10, иргэний 18, эрүүгийн 7, нийт 35 хэрэгт итгэмжлэлээр оролцож, ТӨБЗГ-ын хууль ёсны эрх ашгийг хамгаалсан. Нийт 9 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн бөгөөд бүгд ТӨБЗГ-ын талд шийдвэрлэгдсэн байна.** **Хэрэг тус бүрд хэргийн талаарх танилцуулга бэлтгэн, удирдлагыг мэдээллээр тогтмол ханган, ажиллаж байна. (100 хувь)**

Арга хэмжээ 21.1. (80) Үүссэн хэрэг, маргааны баримт материалын бүрдлийг хангаж, судлан шинжлэх, удирдлагыг мэдээллээр хангах	10.5 сая	- Хэрэг, маргааны талаар судлан шинжилж, холбогдох мэдээлэл, танилцуулга бэлтгэх; - Удирдлагыг мэдээллээр хангах; - Эрх зүйн туслалцаа авсан албан хаагчийн тоо.	2020 оны жилийн эцсийн байдлаар 18 хэрэг, маргаан хянагдаж байна.	- Хэрэг, маргааны баримт материалыг судалж, тайлан мэдээлэл, танилцуулга бэлтгэж, удирдлагыг мэдээллээр хангана; - Холбогдох албан хаагчид эрх зүйн туслалцаа үзүүлсэн байна.	I-IY улирал, ХЭЗХ	Хуулийн байгууллагад шалгагдаж байгаа 35 хэрэг маргааны итгэмжлэлээр оролцож байгаа бөгөөд хэргийн нэгдсэн судалгаа, хэрэг тус бүрийн дэлгэрэнгүй танилцуулга, шүүх хуралдааны тов, хурлын явцын нэгтгэл зэрэг мэдээллийг бэлтгэн тогтмол шинэчилж байна. Газрын даргын шийдвэрээр байгуулагдсан хэрэг, маргааныг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг байгуулан ажилласан бөгөөд 3 хэрэг, маргааны мэдээлэл, танилцуулгыг тухай бүрд нь бэлтгэв. Итгэмжлэлээр оролцож байгаа хэргийн дэлгэрэнгүй танилцуулгад давхардсан тоогоор 106 удаа шүүх хуралд оролцсон буюу ажиллагаа хийгдэх тухай бүрд нь мэдээллийг шинэчилж, хуулийн байгууллагыг болон удирдлагыг мэдээллээр ханган ажилласан байна. (100 хувь)
Арга хэмжээ 21.2. (81) Хууль, хяналтын байгууллагад хянагдаж байгаа хэрэг, маргаанд байгууллагыг төлөөлж ажиллах	15.8 сая	- Хууль, хяналтын байгууллагад хянагдаж буй хэрэг, маргааны төрөл, тоо; - Хэрэг, маргааны бүртгэл хөтөлсөн эсэх; - Хэрэг, маргааны шийдвэрлэлт, хувиар.	- Хянагдаж байгаа хэрэг маргаан – 24; - Шийдвэрлэгд-сэн хэрэг маргаан – 7; - ТӨБЗГ-ын эрх ашгийг хангаж шийдвэрлэгд-сэн хэрэг маргааны хувь – 71.4 буюу 5 хэрэг, маргаан.	- Хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэгдсэн байна; - Хэргийн шийдвэрлэл-тийн явцыг шалгуур үзүүлэлтийн дагуу тухай бүр тайлагнасан байна.	I-IY улирал, ХЭЗХ	Захиргааны 10, иргэний 18, эрүүгийн 7 хэрэгт итгэмжлэлээр оролцож байгаа бол ажлын хэсэг байгуулан судалж байгаа 1 маргаан байна. Тайлант хугацаанд 9 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн бөгөөд бүгд ТӨБЗГ-ын талд шийдвэрлэгдсэн байна. (100 хувь)
Арга хэмжээ 21.3. (82) Хууль, шүүхийн	18.9 сая	- Хамтран ажилласан хууль,	Шаардлагатай нотлох баримт, материалыг	Шаардсан нотлох баримт материалыг	I-IY улирал,	Хууль, хяналтын байгууллагаас ирүүлсэн 56 албан албан бичгийн дагуу нотлох баримт, материалыг

байгууллагаас шаардсан нотлох баримт материалын бүрдүүлэлтийг хангах		хяналтын байгууллагын тоо; - Бүрдүүлсэн нотлох баримт, материалын тоо.	тухай бүр бүрдүүлж, хамтран ажилласан.	тухай бүрд бүрдүүлж, удирдлагад танилцуулан хүргүүлсэн байна.	ХЭЗХ	бүрдүүлэн, “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулан, албажуулж хүргүүлсэн байна. (100 хувь)
НИЙТ ДҮН: **21 зорилт, 82 арга хэмжээний хэрэгжилт дунджаар 98.9 хувь**						

Тайланг нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН Д.ЦЭРЭНЛХАМ